МАНАЙ СОНИНЫ II УЛИРЛЫН ЗАХИАЛГА ЯВАГДАЖ БАЙНА

MMINFO.

19 дэх жилдээ

# МОНГОЛЫН МЭДЭЭ

Хүн ам 3,133.596... ҮСХ-ны өчигдрийн мэдээгээр

2017.03.23. Пүрэв. №054, 055 (4668, 4669) ӨДӨР ТУТМЫН АНХНЫ ЧӨЛӨӨТ ХЭВЛЭЛ Худалдах үнэ 500 төг

УЛС ТӨР

Д.ОЮУНХОРОЛ: АГААР, ОРНЫГ БОХИРДУУЛАГЧ ЭХ ҮҮСВЭРИЙГ 80 ХУВИАР БУУРУУЛНА

II нүүрт

ЦАГ ҮЕ

“АЖНАЙ” Д.БАТ-ЭРДЭНЭ БОКСЫН ХОЛБООГ ЭЗЭНГҮЙДҮҮЛЖ, ШИЛДЭГ ТАМИРЧИД ХОХИРЧ БАЙНА

IV нүүрт



Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

## Д.ОЧИРБАТ:

## 2020 ОН ГЭХЭД ВИРУСЫН ТАРХАЛТЫГ ТАСЛАН ЗОГСООЖ, УСТГАНА ГЭСЭН ТӨЛӨВЛӨГӨӨТЭЙ АЖИЛЛАЖ БАЙНА

Дэлгэрэнгүй ярилцлагыг VI-VII нүүрнээс

ҮЗЭЛ БОДОЛ

## ШИНЭ ЦАГИЙН коммунистууд

Б.ӨНӨРТОГТОХ

У.Черчилль “Улс төрд мөнхийн дайсан гэж байхгүй, мөнхийн найз гэж байхгүй. Харин мөнхийн эрх ашиг л гэж байдаг” хэмээжээ. Энэхүү философи Монголын улстөрчид дунд бичигдээгүй хууль болтлоо хэрэгжсэн. Өдөр нь чуулганы танхимд гахай нохойдоо хүрч хэрэлдэж байсан хоёр улстөрч орой нь нэгнийхээ өрөөнд шатар нүүсэн шигээ инээж суухыг олон ч удаа харсансан. Танхимын гадна нэгэндээ шанаа өгч, хэвлэлээр хэсэгтээ л баалуулсан ч дараа нь юу ч болоогүй юм шиг тэврэлдээд уулзсан жишээг ч уншигч та бид мэднэ. Саяхан даа, АН-ын даргын сунгаанд таван нэр дэвшигч өрсөлдөж нэгнийгээ газар дор ортол муулж билээ. Ялтай, ялгүй, худалч хулгайч бүр болоогүй хятад цустай хэмээн биесээ муулж, доромжилсон. Угтаа бол албан тушаалын төлөө нүүрээ хийх газаргүй болтол шөргөөцөлдлөө. Гэтэл сонгуулийн дараа өнөө тав маань юу ч болоогүй аятай зэрэгцэж суугаад хоол идэж буй зураг цахим орчинд тархсан юм. Яг л мөнхийн дайсан гэж байхгүй мөнхийн эрх ашиг гэж бий гэдгийг харуулсан хэрэг болсон юм.

Үргэлжлэл нь III нүүрт

Дугаарын 60 мөр

## Хуурамч дуудлагын эзэнд хатуу хариуцлага тооцъё

Ж.ОТГОН

Яаралтай тусламжийн 101, 105, 102, 103 утсанд хуурамч дуудлага өгөх, тоглох явдал гарч байгаа талаар албаныхан анхааруулдаг. Эдгээр хуурамч дуудлагуудыг хүүхдүүд өгсөн байдаг. Гэхдээ хүүхэд хуурамч дуудлага өгч тогложээ гээд хариуцлага хүлээхгүй өнгөрдөггүй. Өөрөөр хэлбэл, Захиргааны хариуцлагын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.2 дахь хэсгийг үндэслэн хүүхэд бол эцэг эх, асран хамгаалагчдад нь, иргэдэд цагдаагийн байгууллагаас хариуцлага тооцдог.

Гэтэл энэ удаад насанд хүрсэн согтуу нөхөр утсаар ярихын тулд нийгмийг цочроосон хуурамч мэдээлэл өгсөн тохиолдол гарлаа. Тодруулбал, энэ сарын 21-22-нд шилжих шөнө цагдаагийн байгууллагад “Төмөр замын эмнэлгийн хашаанд автомашиндаа буудуулсан хүн байна” гэсэн мэдээлэл ирүүлсэн байна.

Үргэлжлэл нь III нүүрт

Улаанбаатарт: ӨНӨӨДӨР







ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ

## Д.Нацагдорж хамбын тухай өгүүлэх баримтат кино ирэх зун нээлтээ хийнэ



Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

З.МӨНХСУВД

Их Британийн нэрт найруулагч, продюссер Бэнжамин Жонс ахлагчтай кино багийнхан “Дэлхийн Соён гэгээрүүлэгчид” нэртэй цуврал баримтат кино бүтээж байгаа ажээ. Тэрбээр энэ цувралынхаа хүрээнд Монголын тал нутгийн үзэсгэлэн, ахуйамьдрал, Буддын шашин, уламжлалт анагаах ухааныг Манба Дацан хийдийн Хамба лам Д.Нацагдоржоор дамжуулан дэлхийн үзэгчдэд хүргэхээр болсон байна. Тэгвэл энэхүү баримтат киног бүтээж буй багийн төлөөлөл өчигдөр “Монгол ньюс” мэдээллийн төвд хийж буй уран бүтээлинхээ талаар танилцуулсан юм. “Дэлхийн соён гэгээрүүлэгчид” хэмээх баримтат киноны эхний цуврал “Uncle Max Dulumunmun of the Yuin Nation” нэртэйгээр гарч байжээ.

Үргэлжлэл нь IX нүүрт

ОНЦЛОХ МЭДЭЭ

## ОЛОН УЛС БРАЗИЛ МАХНААС ТАТГАЛЗАЖ ЭХЭЛЛЭЭ



Б.ДАВАА

Бразилын хуулийн байгууллага хугацаа нь дуусч, муудсан мах худалдаалж байсан томоохон сүлжээг илрүүлсэн билээ. Энэ хэрэгт 30 гаруй эрүүл ахуйн байцаагч холбогдон ажлаасаа халагдсан бол гурван мах боловсруулах үйлдвэр хаалгаа барьж, эдүгээ 20 гаруй аж ахуй нэгж шалгагдаж байгаа юм. Бразил нь мах, махан бүтээгдэхүүн экспортлогч улс бөгөөд дэлхийн 150 гаруй оронд мах экспортолдог билээ.

Тэгвэл дээрх дуулиан дэгдсэнтэй холбогдуулан хэд хэдэн улс бразил махнаас татгалзаж эхэллээ.

Үргэлжлэл нь VIII нүүрт

**ХААН банк**

| | Авах | Зарах | | Авах | Зарах |
|---|---|---|---|---|---|
| АМ.ДОЛЛАР | 2450.00 | 2464.00 | ФУНТ | 2993.00 | 3087.00 |
| ЕВРО | 2607.00 | 2680.00 | РУБЛЬ | 41.90 | 43.80 |
| ИЕН | 21.72 | 22.03 | ЮАНЬ | 355.00 | 357.90 |

**Худалдаа хөгжлийн банк**

| | Авах | Зарах | | Авах | Зарах |
|---|---|---|---|---|---|
| АМ.ДОЛЛАР | 2454.00 | 2468.00 | ФУНТ | 3006.00 | 3080.00 |
| ЕВРО | 2613.00 | 2679.00 | РУБЛЬ | 41.73 | 44.82 |
| ИЕН | 21.60 | 22.17 | ЮАНЬ | 355.00 | 358.90 |

*Өчигдрийн 19.00 цагийн байдлаар*

# УЛС ТӨР

МЭДЭЭЛЭЛ

## Ц.Элбэгдорж: Хаврын баяр сайхан цаг ирж буйг бэлгэддэг

Казах зоны хаврын баяр, Наурызын баярыг тохиолдуулан Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж ахмад эрдэмтэн, багш Кылышийн Аксолтаныд зочиллоо. Энэ үеэр Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж нийт казах түмэнд хандаж хэлэхдээ “Баян-Өлгий аймаг болон Монгол нутгийн газар бүр амьдарч, ажиллаж байгаа казах иргэд маань өнөөдөр хамгийн сайхан баяраа тэмдэглэж байна. Хаврын баяр гэдэг бол өдөр шөнө тэнцсэний баяр, хаврын баяр гэдэг бол үртэй бүхэн үржиж, үндэстэй бүхэн цэцэглэдэг ийм сайхан цаг ирж байгааг бэлгэддэг бэлгэдэлтэй сайхан баяр юм. Дээрээс нь ахмадуудаа хүндэтгэж золгодог энэ сайхан уламжлал, ёс заншлаа залуучууд, үрхүүхэддээ уламжлуулдаг ийм сайхан баяр юм. Манай казах түмэн бол их хөдөлмөрч, хичээнгүй хүмүүс. Ажиллаж байгаа газар бүхэндээ их амжилт гаргадаг, их бүтээл бий болгохыг эрмэлзэж сайхан ажилладаг улсууд юм. Өнөөдөр бас монгол хүн сансарт ниссэн баяр давхцаж байгаа. Нийт монгол түмэн маань өөрийнхөө төлөөлөл, өөрийнхөө иргэнийг сансарт нисгэж энэ сайхан хөх дэлхийгээ сансрын уудмаас анх удаа харсан ийм өдөр.Ж.Гүррагчаа гуай хэлж байсан. Сансраас дэлхийгээ харахад хайрлахгүй байхын аргагүй тийм сайхан харагддаг юм гэж байсан. Ийм учраас нийт монгол түмэндээ монгол хүн анх сансарт ниссэн нь технологийн дэвшил, найрамдал, эв хамтын ажиллагааны сайхан үр дүн байсан гэдгийг өнөөдөр дахин дурсаж хэлье гэж бодож байна” гэлээ.

MMINFO.

МОНГОЛЫН МЭДЭЭ

19 дэх жилдээ

Ерөнхий эрхлэгч: С.ГАНТОГОО

Орлогч эрхлэгч Ч.ЧУЛУУНЦЭЦЭГ 99189158

Хариуцлагатай нарийн бичгийн дарга: Э.ЭНХЦЭЦЭГ 90873012

Ахлах редактор: Б.ӨНӨРТОГТОХ 88006842

Шуурхай мэдээлэл, эрэн сурвалжлах алба Н.ПУНЦАГБОЛД 88096454

Улс төр, гадаад мэдээлэл, эдийн засгийн алба: Б.ӨНӨРТОГТОХ 88006842

Гэрэл зургийн алба: Г.АРГУУЖИН 96017873

Компьютерийн алба: Б.ГАНЗОРИГ 99998796

Маркетинг, зар сурталчилгааны алба: Н.АЛТАНЦЭЦЭГ 99173710

Захиалга, борлуулалтын алба: М.ДАВААДУЛАМ 99042510

Э.САЙНЗАЯА 99197866

Дугаарыг эрхэлсэн Н.ПУНЦАГБОЛД

Улсын бүртгэлийн дугаар: 907300528
Индекс: 100757

Редакцийн хаяг: Улаанбаатар хот. Сүхбаатар дүүрэг. Чөлөөт хэвлэл сан /Хэвлэлийн хүрээлэн/. 2 давхар. 209, 211 тоот

Харилцах утас, факс: 976-70113551

“Монголын мэдээ” сонины редакцид эхийг бэлтгэж, “Чөлөөт хэвлэл сан”-ийн хэвлэх үйлдвэрт хэвлэв.

ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ



Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

# Д.ОЮУНХОРОЛ: АГААР, ОРНЫГ БОХИРДУУЛАГЧ ЭХ ҮҮСВЭРИЙГ 80 ХУВИАР БУУРУУЛНА

Ж.ОТГОН

Засгийн газрын хуралдаанаар “Агаар, орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөр”-ийг батлаад байгаа. Тэгвэл энэхүү хөтөлбөрийн талаар БОАЖ-ын сайд Д.Оюунхорол, Ногоон хөгжил, агаарын бохирдлын асуудал хариуцсан орлогч Ж.Батбаясгалан болон бусад албаны хүмүүс мэдээлэл хийлээ. Мэдээллийн эхэнд БОАЖ-ын сайд Д.Оюунхорол “Өвлийн улиралд Улаанбаатар хотын агаарын бохирдол гамшгийн хэмжээнд хүрсэн. Нийслэлийн гэр хорооллын 220 мянга гаруй өрхийн ариун цэврийн байгууламжийн 80 хувь нь доторлогоогүй байгаа нь ус, хөрсний бохирдлын эх үүсвэр, халдварт өвчин дэгдэх суурь нөхцөл болж байна. Ийм Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмжийн дагуу БОАЖЯ-ны ажлын хэсэг, “Агаар, орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөр”-ийг боловсруулж, Засгийн газраар батлууллаа. Хөтөлбөрийн хүрээнд хот төлөвлөлтийг боловсронгуй болгож, дэд бүтцийн байгууламжийн чанар, хүртээмжийг нэмэгдүүлэн түүхий нүүрсний хэрэглээг хязгаарлах, орон нутгийг хөгжүүлж, төвлөрлийг сааруулах зэрэг 60 арга хэмжээг 2017-2025 онд хоёр үе шаттай хэрэгжүүлнэ. Мөн агаарын бохирдлыг бууруулахад иргэд, аж ахуйн нэгжийн оролцоог дэмжихийн зэрэгцээ үүрэг хариуцлагыг нь ухамсарлуулах чиглэлд тодорхой ажил хэрэгжүүлэх болно. Хөтөлбөрийг хэрэгжүүлснээр байгальд ээлтэй инженерийн байгууламжийн чанар, хүртээмж сайжирч, агаар, орныг бохирдуулагч эх үүсвэрийг 80 хувиар бууруулна. Нийслэлийн хэмжээнд түүхий нүүрс хэрэглэхийг бүрэн хориглож, агаар, орны бохирдлыг 50-иас доошгүй хувиар бууруулах юм” гэлээ.

Хөтөлбөрийн хүрээнд агаарын бохирдлыг бууруулах дэвшилтэт техник, технологийг нийтэд танилцуулах “Байгаль орчинд ээлтэй техник, технологийн мэдээллийн төв”-ийг Баянзүрх, Сонгинохайрхан, Чингэлтэй дүүрэгт байгуулах аж. Мөн Ерөнхий сайдаас өгсөн чиглэлийн дагуу Агаарын бохирдлын эсрэг сан байгуулах тухай хуулийн төслөөс гадна байгаль орчныг хамгаалах, агаар, орчны бохирдлыг бууруулах, нөхөн сэргээлт хийх чиглэлээр үүрэг, хариуцлагыг тодорхой болгох, олон нийтийн хяналт, оролцоог нэмэгдүүлэх зорилгоор холбогдох хуулиудад нэмэлт өөрчлөлт оруулах юм байна. Түүнчлэн зорилтот бүлгийг боловсруулсан түлшээр хангах, цахилгаан халаагуур, шөнийн тарифт тоолуур зэргийг худалдан авах айл өрхүүдэд хөнгөлөлттэй зээл олгох журмын төслийг боловсруулжээ. Үүний зэрэгцээ агаар, орчны бохирдлыг бууруулах, цэвэрлэх, дотооддоо нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх зориулалттай тоног төхөөрөмжид татварын хөнгөлөлт үзүүлэх юм байна.

Уг хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд улсын төсөв, агаарын бохирдол, ус бохирдуулсны төлбөрийн орлого, олон улсын байгууллага, хандивлагч орны зээл тусламж зэргээс нийт 9.9 их наяд төгрөг зарцуулах аж. Тухайлбал, 201 тэрбум төгрөгийг улсын төсвөөс, 1.5 их их наяд төгрөгийг гадаадын зээл, тусламжаас, 7.5 их няд төгрөгийг дотоод гадаадын хөрөнгө оруулалтаас, 650 тэрбум төгрөгийг хувийн хэвшлээс, 63 тэрбум төгрөгийг бусад эх үүсвэрээс гаргахаар төлөвлөсөн байна. Үүнээс нүүрнээс нийлэг байгалийн хий гарганавах үйлдвэр байгуулахад таван их наяд төгрөг, Архангай, Баянхонгор, Говь-алтай, Говьсүмбэр, Дундговь, Завхан, Өвөрхангай, Хэнтий аймгийн төвд дулааны станц барихад 325 тэрбум төгрөг, Арьс шир, ноос ноолууран бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн парк байгуулахад 272 тэрбум төгрөг зарцуулах аж. Түүнчлэн Улаанбаатар хотод шинэ цэвэрлэх байгууламж барих, гурван хогийн цэгт хог дахин боловсруулах, устгах үйлдвэр байгуулах юм.

*Мэдээллийн дараа сэтгүүлчид сонирхсон асуултандаа хариулт авав.*

**-Агаар, орныг бохирдуулагч эх үүсвэрийг 80 хувиар бууруулна гэлээ. Тэгвэл түүхий нүүрсний хэрэглээний оронд иргэдэд ямар шийдэл санал болгох юм вэ?**

**Д.Оюунхорол:** Түүхий нүүрсний хэрэглээг бууруулах чиглэлээр үе шаттай ажил хийж байгаа. Эхний ээлжинд эрчим хүчний шөнийн тарифыг тэглэсэн. Түүнчлэн Банкнуудын холбоо, Ногоон зээлийн сантай хамтран орлого багатай өрхүүдэд цахилгаан халаагчийг зээлээр олгоно. Орлогогүй, нэн дуу өрхүүдэд үнэ төлбөргүй олгох асуудлыг шийдвэрлэнэ. Үүнийг нийтийн эрх ашгийн төлөө, төрийн зохицуулалтаас зайлшгүй хийх юм. Агаарын бохирдлыг бууруулах ажлын хүрээнд иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран нийслэлийн есөн дүүрэгт 21 автомашинтай шалгалт хийсэн. Энэ шалгалтын дүнгээр их хэмжээний нүүрс хэрэглэдэг нам даралтын зуухууд агаарын бохирдолд ихээхэн нөлөөлж байгааг тогтоосон. Тиймээс нам даралтын зуухуудыг төвийн нэгдсэн халаалтын сүлжээнд холбох ажлыг эхлүүлсэн.

**Ж.Батбаясгалан:** Нийслэлийн Засаг дарга агаарын бохирдолтой тэмцэх гурван төрлийн захирамж гаргасан. Нэгдүгээрт, орон нутгаас Улаанбаатарыг зорих шилжилт хөдөлгөөнийг түр хугацаагаар хориглосон. 2016 оны арванхоёрдугаар сарын 31-ны байдлаар нийслэлд сая 400 мянга хүн албан ёсны бүртгэлтэй байна. Хоёрдугаарт, суурьшлын бүсийг хязгаарлалтыг тогтоосон. Гэр хорооллын иргэдийн ахуйн хэрэглээний зуух агаарын бохирдолд хамгийн их нөлөөлдөг. Тиймээс Дэлхийн банкаар ахуйн хэрэглээний зуухны стандартыг боловсруулуулсан. Энэ стандарт ирэх сарын 01-нээс хэрэгжинэ. Тиймээс гэр хорооллын өрхүүдийг Дэлхийн банкны стандартад нийцсэн зуухаар солих ажлыг эхлүүлнэ. Өнгөрсөн таван жилийн хугацаанд тараасан зуух Монгол Улсын ахуйн хэрэгцээнд тохирохгүй байгаа юм. Өөрөөр хэлбэл, зөвхөн гэр халаах зориулалттай. Хоол хийх боломжгүй. Тиймээс уг зуухыг Дэлхийн банкны стандартын дагуу ширэмийг нь солиулах зэрэг арга хэмжээг явуулна. Зуухыг төсвийн мөнгөөр тараахгүй. Харин иргэдийн эдийн засгийн санхүүгийн байдалд нөлөөлөхгүйгээр зохицуулах буюу зээлээр олгох талаар Банкуудын холбоотой хамтран ажиллана.

**-Стандартын шаардлага хангасан зуухыг хаана үйлдвэрлэх вэ. Хэдэн төгрөгийн үнэ өртөгтэй байх вэ?**

**Ж.Батбаясгалан:** Нийслэлийн гэр хороололд 210 мянга гаруй өрх байна. Өнгөрсөн таван жилийн хугацаанд 220 гаруй тэрбум төгрөгийг агаарын бохирдлыг бууруулахад зарцуулж, 176 мянган зуух тараасан. Гэр хорооллын 20-30 хувь нь л дээрх зуухыг хэрэглэж байна. Өнгөрсөн Засгийн газар түүхий нүүрсний хэрэглээг чөлөөлснөөр сайжруулсан зуух, түлш үйлдвэрлэдэг аж ахуйн нэгжүүд санхүүгийн хүндрэлд орсон. Одоо бид дотоодод аж ахуйн нэгжүүдээ дэмжинэ. Энэ чиглэлээр дотоодын зуух үйлдвэрлэдэг, худалдан борлуулдаг бүх аж ахуйн нэгжүүдтэй уулзаж байгаа. Зуухны үнийг бид тогтохгүй. Зах зээлийн зарчмаар л явна. Стандартын шаардлага хангасан зуухны тухай мэдээллийн төвийг иргэд Нийслэлийн дөрвөн цэгээс авч болно. Эдгээр цэгийг ойрын хугацаанд Драгон төв, Зургаан буудал, Сансарын худалдааны төв, Дүнжингарав худалдааны төвд байгуулах юм. Түүнчлэн зуух худалдан авахад аль банкнаас ямар нөхцөлтэй зээл авах тухай мэдээллийг ч авч болно.

**-Өмнө нь худалдан авсан Хас, Дөл зэрэг зуухтай иргэд дахиад зуухаа солих уу?**

**Д.Оюунхорол:** Шууд тэгж ойлгож бас болохгүй. Дээрх зуухны ширэм жижиг тул хоол хийж болдоггүй. Тиймээс стандартын шаардлага хангасан зуух худалдан авч, дотоодын үйлдвэрлэлээ дэмжих хэрэгтэй.

МЭДЭЭ, МЭДЭЭЛЭЛ

## Ерөнхийлөгч НҮБ-ын тусгай элчтэй уулзлаа

Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж өчигдөр НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн даргын Замын хөдөлгөөний аюулгүй байдал хариуцсан тусгай элч, Олон улсын Автомобилийн холбооны ерөнхийлөгч Жан Тодыг хүлээн авч уулзлаа. Ноён Жан Тод Монгол Улсад айлчилж буй энэ хугацаандаа Зам, тээврийн хөгжлийн яам, Замын цагдаагийн алба зэрэг газруудад ажиллажээ. Тэрбээр Монгол Улсын замын хөдөлгөөний аюулгүй байдлын асуудлууд болон хамтын ажиллагааны чиглэлээр дээрх байгууллагуудын удирдлагатай ярилцсан байна. Түүнчлэн цаашид хамтран ажиллах талаар санал солилцжээ. НҮБ-аас 2011-2020 оныг “Замын хөдөлгөөний аюулгүй байдлын жилүүд” болгон зарлажээ. Монгол Улс НҮБ-ын замын хөдөлгөөний аюулгүй байдлын холбогдолтой суурь конвенциудад нэгдэн ороход НҮБ-ын зүгээс дэмжиж, хамтран ажиллана гэдгээ илэрхийлсэн талаараа ноён Жан Тод Монгол Улсын Ерөнхийлөгчтэй уулзах үеэрээ хэллээ.

## Монгол Улс сайн дурын илтгэлээ танилцуулав

Нью-Йорк хотноо болж буй НҮБ-ын Эдийн засаг, нийгмийн зөвлөлийн Эмэгтэйчүүдийн аж байдлын комисс (ЭАБК)-ын чуулганд оролцож буй Монгол Улсын Засгийн газрын төлөөлөгчид сайн дурын илтгэлээ танилцууллаа. “Охид, эмэгтэйчүүдийн асуудлаарх Мянганы хөгжлийн зорилтуудын хэрэгжилт, сорилт бэрхшээлүүд” сэдвээр танилцуулсан уг илтгэлд Монгол Улс Мянганы хөгжлийн зорилт (МХЗ)-ын хүрээнд охид, эмэгтэйчүүдийн хүний эрх, жендерийн тэгш байдлыг хангах, манлайлал буюу улс төрийн шийдвэр гаргах түвшин дэх оролцоог нэмэгдүүлэхэд тодорхой амжилтад хүрснийг жишээ баримтаар танилцуулжээ. Улмаар эмэгтэйчүүдийг эдийн засгийн хувьд чадавжуулах, жендерийн мэдрэмжтэй төсөв бүрдүүлэх тогтолцоог бэхжүүлэх, удирдах буюу шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн эзлэх хувийг улам бүр нэмэгдүүлэх, эмэгтэйчүүдийн ажил эрхлэлтийг дэмжих, хувийн хэвшил дэх эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн цалингийн зөрүүг арилгах зэрэг асуудлыг “Тогтвортой хөгжлийн 2030 хөтөлбөр”-ийн хүрээнд хэрэгжүүлэхээр зорьж буйг танилцуулсан байна. Манай улсын илтгэлийн дараа Швейцарийн Холбооны Улс болон Японы төлөөлөгч үг хэлж, МХЗ-ын хүрээнд Монгол Улсын олсон амжилтыг өндрөөр үнэлж буйгаа илэрхийлэхийн зэрэгцээ Тогтвортой хөгжлийн зорилтыг хэрэгжүүлэх үйлсэд хамтран ажиллах эрмэлзлэлээ нотлов.

## Монгол, Вьетнамын хамтын ажиллагааг тогтворжуулна гэв

Худалдаа, эдийн засаг, шинжлэх ухаан, техникийн хамтын ажиллагааны Монгол, Вьетнамын Засгийн газар хоорондын комиссын 16 дугаар хуралдаан энэ сарын 27-30-ны өдрүүдэд Улаанбаатар хотноо болно. Хуралдаан нь хоёр орны найрсаг харилцаа, хамтын ажиллагааг тогтвортой хөгжүүлэх, худалдаа, эдийн засаг, хөдөө аж ахуй болон бусад салбарын хамтын ажиллагааг эрчимжүүлэх, харилцан ашигтай хамтын ажиллагааг дэмжих зорилготой юм байна. Хуралдаанд Монгол Вьетнамын талын төлөөлөгчид ижил тэнцүү оролцоотой байх ажээ.

## Н.Номтойбаяр сайдын санаачилгаар элэгний С вирусийн шинжилгээг үнэ төлбөргүй өгдөг болно

Төрийн ордонд өнгөрсөн мягмар гарагт Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн ээлжит хуралдаан боллоо. ХНХ-ын сайд Н.Номтойбаярын санаачилгаар элэгний С вирусийн идэвхжил тодорхойлох лабораторийн шинжилгээний зардлыг Эрүүл мэндийн даатгалын сангаас бүрэн хариуцахаар боллоо.

Ингэснээр ирэх сарын 1-нээс иргэд С вирусийн шинжилгээгээ үнэ төлбөргүй тогтоолгох боломж бүрдэж байгаа юм. Гэхдээ элэгний С вирус тогтоох лабораторийн шинэжилгээний зардлын дээд хязгаарыг 120 мянган төгрөгөөр тогтоож, даатгуулагчаас нэмэлт төлбөр авахгүй гэсэн шийдвэр гаргажээ. Энэхүү шийдвэрийн дагуу 2017 онд уг шинжилгээний зардалд Эрүүл мэндийн даатгалын сангаас 4.9 тэрбум төгрөг зарцуулах юм. Удахгүй итгэмжлэгдсэн лабораториудын нэрийг зарлах юм байна.

Мөн өнгөрсөн оны арваннэгдүгээр сараас даатгуулагч өөрөө банкаа сонгон тэтгэврээ авах боломж бүрдсэн. Харин 2017 оноос зургаа хүртэлх сарын тэтгэвэртэй тэнцэх хэмжээний зээлийн жилийн хүүг 15 хувь болгон гурван пунктээр бууруулсан юм. Одоогийн байдлаар нийт 23 мянган тэтгэвэр авагч 20.7 тэрбум төгрөгийн зээл аваад байна. Ингэснээр даатгуулагчдыг 2.7 тэрбум төгрөгийн зээлийн хүүгийн дарамтаас чөлөөлсөн арга хэмжээ болсныг ярилцлаа.

ҮЗЭЛ БОДОЛ

# ШИНЭ ЦАГИЙН коммунистууд




**Үргэлжлэл.**
**Түрүүч нь I нүүрт**

Энэ зургаас үүдэж цахим орчинд "Энэ хүмүүс бол дүр эсгэсэн луйварчид, наанаа худлаа жүжиг тавиад цаанаа үгсэн хуйвалдаж байдаг" гэх мэтээр харааж зүхжээ. Бидний цөөхөн монголчууд дотроо хагарч бутарч, хэрэлдэж талцаж байвал сайхан мэт санагддаг болсон нь энэ мэт жишээнээс тодхон. Улс төрд эрх ашиг гэж зүйл байх ч нөгөө талаар эдгээрийг улс төрийн зөв соёл, төлөвшил хэмээн ойлгоход буруудахгүй. Тэр тусмаа өс санасан улс төр монголчуудыг хэзээ ч сайн зүйлд хүргэж байгаагүй учраас өдөр нь маргалдсан ч орой нь эргээд уулзах нүүртэй, уучилж чадах сэтгэлтэй байгааг хүнээрээ үлдсэн хэрэг болов уу хэмээн мунхаглан бодож сууна. Хөшигний наад, цаадах улс төр гэж хүндрүүлж ойлгохоос илүүтэй улстөрчдийн зөв төлөвшил, улс төрийн зөв соёлыг харуулсан энэ мэт олон жишээг дурьдаж болно. Л.Гүндалай гэх "цуутай" улстөрч эр Ц.Нямдорж гишүүнтэй мөн ч олон жил шөргөөцөлдсөн дөө. Тэдний тухай онигоо, бүр цавууны реклам хүртэл гарч байв. Гэтэл Л.Гүндалай Хөвсгөл далайд завьтай төөрч, харин Ц.Нямдорж тушаал гаргаж нисдэг тэрэг явуулан эрэл хайгуул хийж түүнийг олсны дараа Л.Гүндалай дахиж хэзээ ч таньтай үг сөргөхгүй, эр хүн шиг нөхөрлөнө өө хэмээн ам гарсан гэдэг. Тэр ч хэлсэн амандаа хүрч чадсан. Энэ нь жинхэнэ эрчүүдийн нөхөрлөл, хэлсэндээ хүрдэг үнэнч зангийн илрэл болсон юм. Ц.Нямдорж, Д.Лүндээжанцан, Э.Бат-Үүлийн үед ийм л улс төр явж ирсэн. Улс орны эрх ашгийн төлөө зөрчилдөж, маргалдаж, хэрэлдэж, намын эрх ашгийн төлөө нохой гахайдаа хүрдэг ч тэд амьдрал дээр нэгэндээ тус дэм болсон найз нөхөд явах нь олонтай. Хоёр өөр нам, хоёр өөр үзэл бодолтой атлаа амьдралын замд тууштай нөхөрлөж буй олон ч эрчүүдийг бид мэднэ. Намын даалгавраар боловсролгүй гэж хэлсэн юм шүү. Найзыгаа уучлаарай хэмээн олон нийтийн өмнө, телевизээр уучлалт гуйж чаддаг жудагтай улстөрчид Монголын төрд цөөнгүй байлаа. Харамсалтай нь ийм нөхөрлөл, ийм улс төр тэднээр дуусах бололтой. Харин шинэ цагт биднийг ямархуу дүр зурагтай улс төр угтаж буйг хэлж чадахгүй нь. Зах зээлийн шуурган дунд унаж босч бизнес хийж явсан жудагтай эрчүүд, монгол төрийн төлөө цал буурал болтлоо хоёргүй сэтгэлээр зүтгэж яваа жинхэнэ төрийн хар хүний тухай яриа төд удахгүй домог болж яригдах биз ээ. Үнэнээр яваад улс төрд орж ирнэ гэдэг биелэхгүй мөрөөдөл болжээ. Шинэ цагийн улстөрчид дунд цэвэр намтартай хүн тун цөөхөн байгааг ч нуугаад яахав. Ихэнх нь баян айлын нялх Сэнгүмүүд. Аав, ээжийн хөрөнгөөр баруун солгойгүй тоглож, төрд толгойгоороо биш мөнгөөрөө орж ирсэн, улс төрд угсаа залгамжилсан ханхүү нар дэндүү олон болчихлоо. Эсвэл даргын цүнх барьж гүйсээр байгаад албан тушаалд хүрсэн залуу улстөрчид цөөнгүй бий. Тэд өрсөлдөгч намыг юу ч үгүй гишгэж нухчин дарж, санаснаар болдог бол цаазаар авсан ч болно гэсэн өс санасан сэтгэлээр асуудалд ханддаг нь олон зүйлээр илэрдэг. Чуулган, байнгын хороодын хуралдаанд суухад барьж хорь, шоронд хий гэсэн өс хонзонгийн улс төр дандаа залуу үеийнхний амнаас дуулдах болсон нь харамсалтай. Байнгын хорооны даргын чухал албан тушаал эрхэлж буй залуу улстөрч өөрийнхөө аав шиг хүнийг хулгайчаар нь дууддаж, удахгүй шоронд орно оо хэмээн занаж суусан нь саяхных. Ахмад үеэ хүндлэх, ах захаа ойлгох ухаан тэдэнд алга. Өрсөлдөгч бол өвгөн байсан ч чи гэж харьцах нь энүүхэнд. Өөрөө том албан тушаалтай бол настан буурлыг ч өмнөө сөхрүүлэх бодолтой ойворгон залуус дэндүү олширлоо. Өөр нам байтугай, өвөр зуураа ч тэд өс хонзон өвөртлөх болжээ. Нэг намын байранд суудаг ч фракци бүлэглэлээр ялгаварладаг, хов хутгадаг, матдаг, тэр улстөрчийн халаасны хүн гэж хардаг явцуу улс төрийг шинэ цагийн залуус хамгийн сайн хийж байна. Нэг намд харьяалагдлаа гээд үгсэн тохиролц гэсэн үг биш. Гэхдээ албан тушаалд хүрэхийн тулд анд нөхдийнхөөараасэргэлзэхгүйгээр хутга дүрдэг шинэ цагийн коммунистууд дэндүү олширч байгаад л асуудал байгаа юм. Коммунизмаас авах зүйл байсан ч хаях зүйл дэндүү олон байсан. Тэр тусмаа хэлмэгдүүлэлт, нам төрийн эсэргүү нэрээр олон зуун мянган гэмгүй залуусыг орон шоронд хийж явсан гутамшигт түүхээсээ бид ангижрах учиртай. Харамсалтай нь шинэ цагт түүх эргэн давтагдаж байна. Гэхдээ муухайгаар. Өс хонзонгийн улс төр монгол төрд улам л гүн бат байр сууриа эзэлжээ. Нөгөө намын хөгшин, залуу хэнийг ч хамаагүй ажил, амьдрал албан тушаалаар нь ялгаварлан гадуурхаж, үзэн ядаж, гэмгүй байсан ч барьж хориод нэр хүнд олж, албан тушаалд хүрэх гэж улайрч байна, тэд. Ардын нам гарвал ардчиллын буруутай, буруугүй хэн ч бай шоронд орох ёстой. Ардчилал албан тушаалд хүрвэл Ардын намынхан бүгд гудамжинд гарах ёстой гэдэг хууль хэрэгжих болсон. Төрийн албан тушаал ч үнэ цэнээ алдаж, нам гарчихлаа одоо би ажилтай хэмээн баярлаж суудаг болжээ. Намайг тэр үед хөөж, миний албан тушаалыг булаасан нөхрөөс одоо л өшөөгөө авах боломж бүрдлээ хэмээн ярьж байгаа хүмүүстэй ч олон тааралдлаа. Цаашдаа энэ байдал улам л газар авах шинжтэй. Өс хонзонг тэд улс төрийн хамгийн том зэвсэг болгон ашиглах болов. Ахмад үеэсээ дандаа буруу зүйлийг нь сурч үлджээ. Андын нөхөрлөл, улс төрийн зөв төлөвшлийг биш араас нь хутгалж албан тушаалд хүрдэг занг нь хуулчихаж. Нэг ширээнд зэрэгцэж суучихаад л журмын нөхрөө матаж, албан тушаалаар шагнуулж байна, өнөөгийн залуус. Бидний шинэ цаг, ирээдүйн улс төрийн дүр зураг "бөгс долоогч", ухагч, өс санасан Нялх Сэнгүмүүдээр дүүрэх нь. Гэрээ засаад төрөө засах монгол ухааны тухай ч ярих юм биш. Үс зүсээ ч аятайхан янзалчихаж чадахгүй, үг хэлээ ч цэгцэлж чадаагүй, "би-ээр өвчилсөн "цээж өвчтэй" коммунистууд энэ улсыг хаашаа хөтлөхийг төсөөлөхөөс ч аймшигтай. Энэ тухай бодохоос ч айж байна. Бидний үр хүүхэд, ямар гэгчийн нийгэмд амьдрах бол. Үр хүүхдээ үнэнээр явбал амьдрал чамайг шагнана гэж хүмүүжүүлэх эсэхдээ ч эргэлзэж буйгаа нуух юун. Аль нэг даргыг дага, эсвэл намд элсчихээд юу ч хамаагүй ярьж, улстөржиж, нөгөө намаа муулж, орон шоронгоор айлга гэж сургах уу. Монгол Улс урагшаа хоёр алхам хөгжих биш харин хойшоо хоёр алхчихаж. Коммунизм эргэн ирж, шинэ цагт улам л хүчирхэгжиж байна. Шинэ цагт улс төрд нөхөрлөл, дайсан бүр эрх ашиг ч алга болж зөвхөн өс хонзонгийн улс төр ноёлох вий дээ. Шатар нүүдэг нөхөрлөл шанаа өгчихөөд уучилж чаддаг эрчүүдийн хээгүй зан гээгдэж шалихгүй зүйлээр ч нэгнээ өөнтөглөж, өсөрхдөг, улс төр гэдгийг араас нь хэнэггүй хутгалчихаад, албан тушаалд хүрч болдог шат дамжлага хэмээн эндүүрдэг шинэ цагийн коммунистуудад халаагаа тавьж өгчээ.

ӨНӨӨДРИЙН ТОП ИШЛЭЛ



Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

Дугаарын 60 мөр

## Хуурамч дуудлагын эзэнд хатуу хариуцлага тооцъё

**Үргэлжлэл.**
**Түрүүч нь I нүүрт**

Энэхүү мэдээллийн дагуу Төмөр зам дахь цагдаагийн газрын жижүүрийн бүрэлдэхүүн, Баянгол дүүрэг дэх цагдаагийн нэг, хоёрдугаар хэлтсийн алба хаагчид хойшлуулашгүй ажиллагаа явуулан ажиллаж, уг мэдээлэл нь ор үндэслэлгүй, худал болохыг олж тогтоосон байгаа юм. Улмаар энэхүү худал мэдээллийг тараасан этгээдийг эрэн сурвалжилж Баянгол дүүргийн дөрөвдүгээр хороонд оршин суух, 1962 онд төрсөн, эрэгтэй Ж гэгч тараасан болохыг тогтоон, шалгаж эхэлжээ. Харин иргэн Ж болсон үйл явдлын талаар "Тухайн үед согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэсэн байсан. Гэрээсээ гараад утсаар ярих гэтэл нэгж дууссан байсан. Тэгээд утсаар ярихын тулд ойролцоох эмийн санд орж Төмөр замын эмнэлгийн хашаанд автомашиндаа буудуулсан хүн байна" гэж худал хэлсэн. Тэр мэдээллийг эмийн сангийнхан 102-т хэлсэн юм байна. Би ийм зүйл болно гэж мэдээгүй. Энэ мэт худал мэдээллэл тарааж, цагдаад худал мэдээлэл өгч болдоггүй юм байна. Миний худал хэлсэн үг иргэдийг цочроож, цагдаагийн байгууллагад маш их хүндрэл учруулллаа" гэж хээвнэг яриад сууж байх жишээтэй. Түүний худал мэдээлэл өгч буй дүрс нь хяналтын камерын бичлэгт үлдсэн учир төвөггүй бариад авсан байгаа юм. Уг нь 50 шүргэж яваа энэ иргэн хуурамч дуудлага өгч тоглохын оронд тусгай дугаарын утас руу залгаж, хуурамч мэдээлэл ирүүлэх нь хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгө хохирох эрсдэлтэй учраас тэдний ажилд хүндрэл учруулахгүй байхыг үр хүүхэд, ач, гучдаа заадаг баймаар.

Хэн нэгэн нь хуурамч дуудлага өгч тоглож байх хооронд айл шатаж, гамшиг осолд хүн амиа алдаж байвал яах юм. Угаасаа ч хуурамч дуудлагын гайгаар цаг алдсанаас болоод тэдэн хүн эд хөрөнгө, эрүүл мэнд, амь насаараа хохирсон гэсэн тоо, баримт байж л байгаа. Гэхдээ яг таг гаргах боломжгүй байх.Одоо ямар ямар дугаараас залгасан байна, хэн гэдэг хүн эзэмшиж байна гэдгийг нь олж чадахгүй гэх биш. Угаасаа манай улсад хариуцлагын тогтолцоо сул байгаа болохоор хүмүүс дур зоргоороо авирласаар л байгаа юм. Тийм болохоор энэ асуудал дээр хариуцлагын тогтолцоог маш сайн боловсруулж, торгуулийг нь нэмэх хэрэгтэй. Тэгж байж л хуурамч дуудлага өгөх асуудал багасах биз.

# ЦАГ ҮЕ

ХӨНДӨХ СЭДЭВ

## “АЖНАЙ” Д.БАТ-ЭРДЭНЭ




Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

# БОКСЫН ХОЛБООГ ЭЗЭНГҮЙДҮҮЛЖ, ШИЛДЭГ ТАМИРЧИД ХОХИРЧ БАЙНА

Н.ПУНЦАГБОЛД

Монголын төр спортоо тийм ч анхаардаггүй. Анхаарах ч тэнхэлгүй байгаа шүү дээ. Шигшээ багийн хэдэн тамирчныхаа л зардал мөнгийг дааж чадвал их юм болчихоод байгаа. Яах вэ, сүүлийн үед амжилт гаргасан тамирчид цалин мөнгө аваад, амьдрал ахуй нь гайгүй сайжирч байгаа нь үнэн. Гэхдээ л амжилт гаргахаар зүтгэж байгаа тамирчид бор зүрхээрээ л зүтгэж байна. Мөн олон спорт төрийн ивээлийн гадна үлддэг. Тийм болохоор спортын холбоод нь өөрсдөө л олигтой ажиллахгүй бол болохгүй. Дотроо эвтэй, найртай, багш дасгалжуулагчид, тамирчид нь нягтарч чадсан холбоо амжилт гаргаж байна. Түүний нэг жишээ жүдо. Харин сөрөг жишээ нь Чөлөөт бөхийн холбоо. Эв түнжин муудсанаас болоод тамирчид нь Олимпийн наадмаас медаль хүртэж чадаагүй шүү дээ. Тэгвэл тэдний араас Боксын холбоо орох нь ээ. Уг нь сүүлийн жилүүдэд олимп, дэлхийд боксынхон тун ч амжилттай оролцож ирсэн. Гэхдээ 2008 оноос хойш амжилт нь буурч эхлээд байна. Ядаж байхад саяхны үйл явдлууд энэ холбоо менежмент муутай, Ерөнхийлөгч нь анхаарч ажилладаггүй, багш, дасгалжуулагчид нь тамирчидтайгаа нягт уялдаа холбоогүй ажиллаж байгаа гэдгийг харуулчихлаа. Монголын Боксын холбооны Ерөнхийлөгчөөр “Ажнай” тодотголтой Д.Бат-Эрдэнэ ажилладаг. Мөнгөтэй юу гэвэл мөнгөтэй л хүн. Гэхдээ Боксын холбоог тийм ч сайн удирдаж чадахгүй байна. Энэ холбоонд олигтой шинэ, шинэлэг зүйл хийж чадсангүй. Харин ч уруудуулаад байна. Түүний нэг жишээ дасгалжуулагч нартай тийм ч таарамжтай харилцаж чадахгүй байгаа явдал. Мань эр Боксын холбооны Ерөнхийлөгч болоод дараахан нь зарим нэг дасгалжуулагчийн эрхийг хасч барьж баахан юм болгосон. Мэдээж боксынхон, бокс сонирхогчид тийм ч таатай хүлээж аваагүй нь ойлгомжтой. Одоо бол боксын дасгалжуулагчид, тамирчид наанаа холбооны Ерөнхийлөгчөө магтах шинжтэй л байдаг. Гэвч цаагуураа янз бүрийн асуудал яригддаг болоод байна. Боксчид Спортын төв ордны гадаа халамцуу ирж, архины мөнгө татдаг ч гэх шиг. Санаанд оромгүй явган яриа гарах болж. За энэ мэт дэл сул яриаг тэгсгээд орхиё гэж бодъё. Гэтэл хамгийн сүүлд болсон үйл явдал олон зүйлийг өгүүллээ. Уг нь боксын спортынхноос бас нэг дасгалжуулагч гавъяа зүтгэлээ үнэлүүлж, төрийн одон медаль хүртэж, сүрхий л байсан. Гэтэл цэргийн баярын үеэр гадаад руу тэмцээнд явахаар Хандгайтад бэлтгэлд гарчихсан байсан шигшээ багийн тамирчид шөнөдөө оргоод, Улаанбаатарт ирж цэнгээний газар орсон байгаа юм. Улмаар жирийн иргэдтэй муудалцаж, зодоон цохион хийж, бэртэл гэмтэл авчихаад байна. Цаашлаад боксын гурван дасгалжуулагч хоорондоо зодоон цохион хийсэн яриа ч дарин дээр давс нэмчихлээ. Энэ мэт үйл явдлаас болоод Монголын хамгийн ирээдүйтэй гэгдэх зарим нэг шилдэг тамирчид эрхээ хасуулчихаад байж байна. Яагаад тамирчид шөнө дөлөөр оргох болов. Тэр хооронд дасгалжуулагч нар юу хийж байсан юм бэ. Зарим эх сурвалжууд архидан согтуурч байсан талаар хэлээд байгаа. Спортынхон бол хариуцлагатай, эх орон, ард түмнийхээ өмнө хүлээсэн үүргээ нэр төртэй биелүүлэхийн төлөө явдаг хүмүүс. Гэтэл яагаад тамирчид шөнө бэлтгэлээсээ гарч, Улаанбаатарт ирэв. Наанаа оргосон гээд яриад байгаа болов ч яг тэгсэн үү. Холбооны үйл ажиллагаатай холбоотойгоор асуудал үүсч, дасгалжуулагч, тамирчингүй сэтгэлээр унасан юм биш биз дээ. Түүнээс биш боксчид тэмцээнд явах гэж бэлтгэл хийж байж оргож гарч ирмээргүй л юм. Бүр гайхаад байна. Ер нь тамирчид, дасгалжуулагчдыг буруутгахаас гадна холбоогч бас мартаж болохгүй шүү дээ. Холбооны үйл ажиллагаа яаж доголдож байгааг харуулсан нэг жишээ байна. Тодруулбал, Боксын холбооны хурал энэ сарын 01-нд болсон гэнэ. Тэгэхдээ энэхүү хурлыг Х.Алтанхуяг багш, Д.Төрбат нарын санаачилгаар хийсэн бөгөөд хуралд боксын холбооны нэр бүхий гишүүд болох Э.Бадар-Ууган, Д.Бумансахъяа, Б.Түвшинбат нар тодорхой шалтгааны улмаас оролцоогүй аж. Харин энэ хурал Ерөнхий нарийн бичгийн дарга Ц.Батнасан руу чиглэсэн, түүнийг шүүмжлэх шинжтэй болсон гэж тэрбээр протокол хөтлөхдөө тэмдэглэжээ. Тодруулбал, “Энэ оны нэгдүгээр сарын 16-ны хуралд Ерөнхийлөгчийн тавьсан 2013-2016 онд хийсэн ажлын тайлангийн санхүүгийн тал дээр маш том алдаа гаргаж худал мэдээлэл өгч нийт хуралд оролцогчдод үнэн зөв мэдээлэл өгөөгүйгээс болж өнөөдрийн энэ хүндрэлтэй асуудал үүслээ гэж зад загнах шүүмжлэх хоёрыг хослууллаа. Үүнд би хариулахдаа “Ерөнхийлөгч өөрийн хүсэлтээр ажлаа өгнө гэсэн учир нийт Монголын боксчид дундаа хийсэн ажилтай, сайн ажилласан гэсэн сэтгэгдэл үлдээхийн тулд тийм тайлан бичиж өгсөн юм. Хүндэт Ерөнхийлөгч болгоод сайхан үдэж гаргаж өгнө гэж бодоод тийм юм бичсэн намайг уучлаарай гэсэн” хэмээжээ. Түүнчлэн энэхүү хурлаар өнгөрсөн хугацаанд юун дээр алдав хойшид яах вэ гэдэг талаар ярьсан аж. Хурал дээр ярьсныг сийрүүлбэл, “2016 онд 16 жил тасалдаад эргэн хийж эхэлсэн “УЛААНБААТАР ЦОМ” Олон улсын тэмцээнд яагаад Ерөнхийлөгч оролцоогүй вэ. Боксод сэтгэл зүрхээ өгсөн байтугай хаа хамаагүй гадны хүмүүс хүртэл тусалж байхад, энэ бол үнэхээр ойлгохын аргагүй юм. Үүнийг өөрөөс нь асууж тодруулах хэрэгтэй гэсэн. Анх Ерөнхийлөгч болдог жилээ буюу 2013 онд ганц удаа шинэ жил хийсэн. Түүнээс хойш хийсэнгүй. Бид нийлж архи дарс ууж, идэхдээ биш тухайн жилийнхээ ажлыг дүгнэж дараа жилийнхээ ажлыг товлож шилдэг дасгалжуулагч, шүүгч, тамирчин, клуб зэргээ тодруулж тэднийгээ жаахан шагнаж урамшуулаад л болох юмыг хийсэнгүй. Холбоонд ажиллаж байгаа дөрвөн л хүн байна. Тэд цалин гэж юм авч байгаагүй гэнэ. Энэ арай болохгүй ээ. Яаж амьдрах юм. Мөн холбооны урсгал болон тогтмол зардлыг гаргаж байгаагүй гэнэ. Ингэвэл бид яаж цаашаа явах юм бэ гэдгийг бүгд л ярьж байна” гэсэн байна. Түүгээр ч барахгүй, хурлаар хэлэлцсэн бас нэг гол асуудал бол төсөв. Хуралд оролцогчид “Улсаас манай холбоонд 2017 онд 519 сая төгрөгийг тэмцээн уралдаан, бэлтгэл цугларалтанд зориулж баталсан гэсэн. Харин манай холбоо нийт 480.1 сая төгрөгийн төсөв гаргасан байгаа. Үүнээс хэдийг нь гаргасан юм ер нь гаргах юм уу, хэрэв гаргана гэвэл төсвөө батлаад гаргах хэрэгтэй байна гаргаж чадахгүй гэвэл бид өөр хүнийг Ерөнхийлөгчид санал болгож ажлаа явуулахгүй бол үнэхээр байдал маш хэцүү байна. Тамирчид ямар ч хэрэглэл материалгүй болсон, хуучин ерөнхийлөгчийн үед авсан юм одоо дууссан цаашаа яаж явах юм” гэх зэргээр зовлон жаргалаа ярьсан ч энэ нь тус холбооны удирдлагуудад хүрээгүй бололтой. Учир нь энэ хурлын дараа бүгдээрээ Ерөнхийлөгчөө дуудаж уулзаж энэ талаар ярья гэхэд нь хурал даргалсан хүмүүс эхэлж уулзаад, хурлын талаар ярья гэж хэлээд тараасан гэнэ. Энэ мэтээр маш олон асуудал Боксын холбоонд үүсчихээд байна. Ядаж байхад Э.Цэндбаатараас авахуулаад шинэ залуу шилдэг тамирчид эрхээ хасуулаад өнгөрлөө. “Ажнай” Д.Бат-Эрдэнэ хэрвээ холбоог удирдана гэвэл энэ спортод элэгтэй хандах хэрэгтэй байна. Үгүй бол өөр хүнийг сонгох цаг аль хэдийнэ болсон юм биш үү. Хэрвээ Боксын холбоо энэ мэтээр хөл толгой нь олдохгүй яваад байвал байдал улам л хэцүүдэх нь.

> ...Спортынхон бол хариуцлагатай, эх орон, ард түмнийхээ өмнө хүлээсэн үүргээ нэр төртэй биелүүлэхийн төлөө явдаг хүмүүс. Гэтэл яагаад тамирчид шөнө бэлтгэлээсээ гарч, Улаанбаатарт ирэв. Наанаа оргосон гээд яриад байгаа болов ч яг тэгсэн үү. Холбооны үйл ажиллагаатай холбоотойгоор асуудал үүсч, дасгалжуулагч, тамирчингүй сэтгэлээр унасан юм биш биз дээ...

МЭДЭЭЛЭЛ

# Аюултай ачаа тээвэрлэгчдийг чадавхижуулах сургалт боллоо

Н.БАТЗАЯА

Автотээврийн үндэсний төв энэ жилийг авто тээврийн менежментийг сайжруулах жил болгон зарласан. Энэ хүрээнд автотээврийн салбарын удирдлагууд болон аж ахуйн нэгж байгууллагын ажилчдад чиглэсэн сургалт, зөвлөгөөнийг шат дараатайгаар зохион байгуулж байгаа билээ. Тухайлбал, Автотээврийн үндэсний төвийн удирдлага, мэргэжилтнүүдэд мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх үндэсний зөвлөгөөнийг тус тус зохион байгуулсан юм. Тэгвэл өчигдөр Зам тээврийн хөгжлийн яам, Автотээврийн үндэсний төв, Цагдаагийн ерөнхий газрын иргэдэд үйлчлэх төв болон Нийслэлийн мэргэжлийн хяналтын газар хамтран “Аюултай ачаа тээвэрлэгч аж ахуйн нэгж байгууллагуудын чадавхийг бэхжүүлэх, мэргэшүүлэх сургалт”-ыг аюултай ачаа тээвэрлэгч аж ахуйн нэгж байгууллагуудын дунд зохион байгууллаа. Тус сургалтын нээлтэд АТҮТ-ийн дэд захирал Ш.Батсайхан, АТҮТ-ийн Тээвэр зохицуулалтын хэлтсийн дарга Д.Батбаяр нар оролцов. Сургалтыг нээж АТҮТ-ийн дэд захирал Ш.Батсайхан “Бид бүх тээврийн байгууллагыг мэдлэг, мэдээллээр хангахаас гадна, чадавхижуулж сургалт явуулахад анхаарч ажиллаж байна. Энэ хүрээнд аюултай ачаа тээвэрлэгч аж ахуйн нэгж байгууллагуудыг урин мэдээлэл солилцож, тулгамдаж буй асуудлаа ярилцахаар энэ удаагийн сургалтыг зохион байгууллаа. Сургалтын дүнд аюултай ачаа тээвэрлэгч аж ахуйн нэгж байгууллагууд нэгдсэн ойлголттой болох, холбогдох мэдээллийг цаашдын үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллах, тулгамдаж буй асуудлуудын талаар санал солилцож, шийдэлд хүрнэ гэдэгт итгэж байна” гэв. Энэхүү сургалтыг улс хоорондын ачаа тээвэрлэгч гэрээт аж ахуйн нэгж байгууллагуудын чадавхийг бэхжүүлэх, мэргэшүүлэх, тулгамдаж буй асуудлыг хэлэлцэх болон мэдээлэл солилцох зорилгоор зохион байгуулсан гэдгийг холбогдох мэргэжилтнүүд онцолж байлаа. Мөн тус сургалтын хүрээнд тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл тээвэрлэх үйл ажиллагааны журам, аюултай ачаа тээвэрлэх тээврийн хэрэгсэлд хяналт, шалгалт тавих, хөдөлгөөний аюулгүй байдал болон GPS, аюултай ачаа тээвэрлэх мэргэшсэн жолоочид тавигдах шаардлага, Төрийн хяналт, шалгалтын тухай хууль зэрэг сэдвийн хүрээнд мэдээлэл өгсөн юм. Энэ үеэр холбогдох албаны мэргэжилтнүүдтэй уулзаж, ярилцлаа.

## Д.Батбаяр:Аюултай бодис тээвэрлэдэг аж ахуйн нэгжид зөрчил илрэх болсон

*/АТҮТ-ийн Тээвэр зохицуулалтын хэлтсийн дарга/*

**-Аюултай ачаа тээвэрлэгч аж ахуйн нэгж байгууллагуудын чадавхийг бэхжүүлэх, мэргэшүүлэх сургалт”-ыг зохион байгууллаа. Сургалтыг яагаад зохион байгуулах болов?**

-Манай Автотээврийн үндэсний төв 2017 оныг тээвэрлэлтийн менежментийг сайжруулах жил болгон зарласан. Үүнтэй холбогдуулан чиглэсэн сургалтыг зохион байгуулж байна. Үүний нэг нь аюултай ачаа тээвэрлэгч аж ахуйн нэгж байгууллагуудын чадавхийг бэхжүүлэх, мэргэшүүлэх сургалт юм.

**Үргэлжлэл нь IX нүүрт**

# ОНЦЛОХ ХУУДАС

## Õýí íü õýí áý?

# БАТЛАН ХАМГААЛАХ САЛБАРЫГ АВЧ ЯВАХ ХУРАНДАА НАР

Г.ОЧИР

*Үндэсний өдөр тутмын “Монголын мэдээ” сонин “Хэн нь хэн бэ” булангаараа яамдын харьяа агентлагуудын дарга нарыг онцолж байгаа билээ. Өмнө нь ХЗДХЯ-ны харьяа агентлагуудыг онцолсон бол өнөөдрийн дугаартаа Батлан хамгаалах яамны харьяа газруудын дарга нарыг онцоллоо. Учир нь энэ салбар Зэвсэгт хүчний жанжин штаб гэх цорын ганц агентлагтай тул яамны харьяа газруудын дарга нарын талаар өгүүллээ.*




## Азтай, одтой тэрбумтан генерал

Зэвсэгт хүчнийхэн Жанжин штабынхаа даргаа ийн хэлдэг юм билээ. Зэвсэгт хүчний Жанжин штабын дарга, дэслэгч генерал Ц.Бямбажав 2015 оны зургадугаар сард албан тушаалаасаа чөлөөлөгдөх хүсэлт гаргах үед Монгол Улсын Ерөнхийлөгч бүрэн эрхийнхээ хүрээнд Зэвсэгт хүчний Жанжин штабын Цэргийн хангалт, үйлчилгээний газрын дарга, бригадын генерал Д.Давааг Зэвсэгт хүчний Жанжин штабын даргын албан тушаалд томилуулах асуудлыг УИХ-д хүргүүлснээр хурандаа Д. Даваагийн мөрөн дээр генералын алтан утас бүхий мөрдэс гялалзаж эхэлсэн түүхтэй. Тэрбээр 1963 онд төрсөн. Ховд аймгийн харьяат. Энэ эрхмийг анх гаргаж ирсэн хүн нь УИХ-ын гишүүн Лу.Болд. Тодруулбал, 2008 онд Батлан хамгаалахын сайдаар томилогдсон даруйд БХИС-ийн Цэргийн дээд сургуулийн тэнхмийн эрхлэгчээр ажиллаж байсан Д.Даваag яамандаа татаж авчиран Батлан хамгаалах яамны санхүү, хөрөнгө оруулалтын газрын хэлтсийн дарга болгон дэвшүүлж өөд татсан байдаг. Ийн ажиллаж байтал нутаг нугийнх нь хүн дэд сайдаар томилогдсон нь Даваагийн хувьд чухамхүү албан тушаалын од гийх гээч болж, Зэвсэгт хүчний Жанжин штабын Цэргийн хангалт, үйлчилгээний газрын даргаар томилогдсон нь ЗХЖШ-ын дарга, хошууч генерал Ц.Бямбажавт ойр байх, шадарлан нөхөрлөх боломж бүрдсэн гэж хэлж болно. Ер нь мань эр сүүхээтэй нэгэн л дээ. БХИС-д ажиллаж байхдаа л салбарын хэмжээнд зарлагдсан бүх тендерийн 60 хувийг өөрийн болгодог байсан гэх яриа байдаг. Яаманд ирж, албан тушаал дэвшсэн хойно оо ч эрхэм генерал зүгээр байгаагүй аж. Монгол Улсын хилээр орж ирэх эрхгүйн улмаас Эрээний хил дээр бүтээлгээстэй хэсэг хэвтсэн 50 ширхэг ниссан маркын автомашины асуудал л түүнтэй холбоотой байж магадгүй гэнэ. Дашрамд дуулгахад, уг байлдааны машиныг манай энхийг сахиулагчид Сахар улсад үүрэг гүйцэтгэхдээ ашиглаж байгаад Чад руу шилжүүлсэн байдаг. Монгол Улсын Ерөнхийлөгч энхийг сахиулагчдаа эргэж очиход нь кондейшнгүй машинтай үүрэг гүйцэтгэж байгаагаа дуулгаснаар анх энэ асуудал хөндөгдсөн билээ. Ерөнхийлөгчийн том хүү яг тэр үеэр Сахарт үүрэг гүйцэтгэж байсан юм. Энэ мэтчилэнгээр нааш цааш болгосон зүйлээсээ ашиг олсон Даваа генерал эдүгээ хувьдаа таван орон сууц худалдаж авч чадахуйц бэл бэнчинтэй болсон байж мэднэ. Түүний унаган мэргэжил ар тал. Тэрбээр ЗХУ-ын Вольск хотын Цэргийн ар талын дээд сургуулийг 1994 онд, Санкт-Петербург хотын Цэргийн ар тал, тээврийн академийг Цэргийн ар талын команд штаб, оператив тактикийн мэргэжлээр төгссөн. Ажил амьдралынхаа гараaг Монголын ардын армийн 162 дугаар ангид хүнс, хувцасны албаны даргаар эхэлж ангийн хүнсний хангалтын тасгийн дарга, захирагчийн орлогч, ар талын дарга, Батлан хамгаалахын их сургуулийн Цэргийн дээд сургуулийн тэнхмийн эрхлэгч, ар тал эрхэлсэн дэд захирал, Батлан хамгаалах яамны Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн даргаар тус тус ажилласан.

## Цэргийн аж үйлдвэрийн нэгдлийн дарга, хурандаа Б.Коля

“Эх сурвалжуудын мэдээллээр Батлан хамгаалах яамны тус яамтай хийсэн гэрээгээ шинэчлэхээр ирсэн гадаадын иргэдээс мөнгө нэхсэн гэнэ. Тодруулбал, өнгөрсөн долоо хоногт дээрх шалтгаанаар уулзсан гадаадын иргэдэд “...Гэрээний үнийн дүнгийн 10 хувьтай тэнцэх мөнгийг БНСУ дахь иим дансанд хий. Эс тэгвээс гэрээг сунгахгүй” гээд Б.Бат-Эрдэнэ сайд ч үүнд хамаатай, мэдэж байгаа гэсэн зүйлийг хэлсэн байна. Харин ажил гүйцэтгэгч гадаадын иргэд энэ талаар АТГ-т гомдол мэдүүлжээ. Тиймээс АТГ-ынхан энэ сарын 18-нд Б.Коля хурандаагийн өрөө болон Батлан хамгаалах яаммны Санхүүгийн албаны өрөөг лацдаад шалгаж эхэлсэн байна”. Энэ бол “Батлан хамгаалах аж үйлдвэрийн нэгдэл” ТӨҮГ-ын захирал, хурандаа Б.Колягийн талаархи цахим ертөнцөөр цацагдсан хамгийн сүүлийн үеийн мэдээлэл. Хурандаагийн хувьд уг албан тушаалд хоёр дахь удаагаа томилогдон ажиллаж буй. Өмнө нь Батлан хамгаалах яамны Мэдээлэл, хяналт шинжилгээ, үнэлгээний газрын дарга, тус яамны харьяа Цэргийн дүрэмт хувцасны “Бөртэ” ТӨҮГ-ын захирлаар ажиллаж байсан юм. Энэ эрхэм батлан хамгаалах салбарт гай ч тарьсан, гавьяа ч байгуулсан л байх.

## Бор зүрхээрээ яваа хурандаа

Цэргийн хувцасны “Бөртэ” үйлдвэр бол Батлан хамгаалах салбарын эдийн засгийн чадавхид хамгийн их үүрэг хүлээдэг аж ахуйн нэгж байх. Тиймдээ ч үе үеийн сайд, дарга нар тус үйлдвэрийн даргаар өөрийн итгэлт хүнээ тавьсаар ирсэн байдаг. Шулуухан хэлэхэд, мөнгө олдог хоёр газрын нэг нь гээд хэлчихэд буруудах зүйлгүй л боловуу. Үйлдвэрийн даргаар гурван жил ажиллаад дараагийн албан тушаалд томилогдохдоо дандаа өсч дэвшсэн байдгаас харахад, хэн дуртай аавын хүүгийн сарвайгаад авдаг албан тушаал ч биш байж мэднэ. Өмнө нь даргаар ажиллаж байсан хурандаа нар “Бөртэ”-гөөс чамгүй хөрөнгөжсөн гэх яриа ч байдаг л юм билээ. Бэлэн мөнгөө халааслаад л материал сонгох нэрээр хилийн дээс алхдаг нь ч бодит үнэн. Харин хурандаа Б.Батбаатарыг армийхан “бор зүрхээрээ яваа хурандаа даа” хэмээн тодорхойлсон. Мэргэжил нь ч ар тал. Тэрбээр ЗХ-ний 310 дугаар ангийн захирагчаар ажиллаж байгаад Батлан хамгаалах яам, ЗХЖШ-ын харьяа Үйлчилгээ, аж ахуйн нэгжийн хэлтсийн даргаар ажиллаж байгаад Батлан хамгаалахын сайд Б.Бат-Эрдэнийн тушаалаар Цэргийн хувцасны “ Бөртэ” үйлдвэрийн даргаар томилогджээ. Архангай аймгийн харьяат гэдгийг нь тодотгох нь зөв байх. Зэвсэгт хүчинд сүүлийн үед Архангайн фракц бий болоод байгаа. Нутгийн ах нарын нөмөр нөөлөг байж л таарна. Өмнөх дарга нарынхаа замаар цогиж одчихгүй л бол хүнийхээ хувьд эр хүн гэж л салбарынхан нь магтацгаасан юмдаг. Цаг хугацаа харуулах буй за.

## Сайн хүү, нүнжигтэй хүргэнтэй дарга

БХЯ-ны харьяа “Бага Баян” цэргийн амралтын даргын албан тушаалд хэд хэдэн хурандаа өрсөлдсөн боловч Сү-гийн фракцын өмнө гишгэх хурандаа тодорсонгүй. Энэхүү албан тушаалд ГЕГ-ын дарга Б.Асралтын аав, УИХ-ын гишүүн Сү.Батболдын эхнэрийнх нь том ах, бэлтгэл хурандаа Чимэдийн Батболд шинэ оны өмнөхөн томилогдсон билээ. Энэ эрхмийг амралтын газрын даргаар томилогдох үед “Зэвсэгт хүчинд тэтгэвэртээ гарсан хурандаагаас өөр хүн олдоогүй юм байх даа” гэх яриа гарч олон хүн тэрхүү сонгон шалгаруулалтыг эсэргүүцэж байсан гэдэг. Тэрбээр тэтгэвэртээ гарахаас өмнө БХЯ, ЗХЖШ-ын харьяа Үйлчилгээ аж ахуйн газрын даргаар ажиллаж байсан юм.

## “Алдар”–ын Өсөхөө аварга

Их спортод өөрийн зам мөртэй их аваргатай барьцалдах, хийж бүтээснийг нь үгүйсгэх хүн зэвсэгт хүчинд байтугай Монгол Улсад үгүй биз ээ. Энэ эрхмийн талаар мэдэхгүй хүн гэж үгүй болохоор түүний тухай өгүүлэх нь илүүц юм. Монгол Улсын хэмжээнд төдийгүй олон улсад “ Алдар” нийгэмлэгийн тамирчид алдар суугаа дуурсгасаар байгаа нь түүний их спортыг хөгжүүлэхийн төлөө оюун бодлоо дайчлан ажиллаж байгаагийн илрэл буй за. Чин үнэнийг хэлэхэд, эх орондоо адлагдах шахаад байгаа өвлийн спортод Г.Өсөхбаяр аварга, “Алдар” нийгэмлэг л санаа тавьж, бэлтгэл сургуулилт хийх нөхцлөөр хангаж байгаа билээ.

## “Соёмбо” сонин хэний гарт очсон бэ

Их зохиолч Д.Нацагдорж, их бичгийн хүн Жадамбаа нар анх 1924 онд эрхлэн гаргасан Улаан-Од сонин эдүгээ цагийн аясаар өөрчлөгдөн нэрээ хэдэнтээ сольсоны эцэст “Соембо” гэдэг дээр тогтож буй. Эдүгээ 2000 гаруй уншигчтай, Зэвсэгт хүчний үйл ажиллагааг сурталчилдаг тус сонинг нэг үе 200 уншигчтай болж, эдийн засгийн хувьд бие даах чадвартай болсон тэр үед тухайн үеийн ЗХЖШ-ын дарга, дэслэгч генерал Ц. Тогоо арга хэмжээ авч анхаарал хандуулсны буянаар хөл дээрээ баттай зогссон гэдэг. Харамсалтай нь саяхнаас Батлан хамгаалах яамны мэдэлд очоод буй. Ерөнхий эрхлэгчээр нь Т.Батсайхан гэх залуу томилогджээ. Тэрбээр Япон улсад нийгмийн ухааны чиглэлээр мэргэжил эзэмшсэн нэгэн аж. Түүнийг БХИС-ийн сургалтын албаны дарга асан Т.Соронзонболдын дүү гэдгээр нь энэ салбарынхан анддаггүй юм билээ. Сайн ахын буянаар арлын оронд боловсол эзэмшсэн хэдий ч хэвлэл мэдээлэл гэдэг хэн дуртай нийгмийн ажилтны үзэгний үзүүрээр үйл ажиллагаа нь хэвийн явдаг байгууллага биш гэдгийг Бат-Эрдэнэ сайд мөд мэдрэх биз ээ.

## Хэвлэлийнхний сайн нөхөр Л.Гантөмөр

Хурандаа Л.Гантөмөрийг армийнхан байтугай хэвлэлийнхэн андахгүй. Нэгэн цагт ЗХЖШ-ын хэвлэлийн төлөөлөгчөөр ажиллаж байхдаа тэрбээр хаалттай ертөнцийг ил болгосон гэж хэлж болно. Түүнд аль нэг анги нэгтгэлийн үйл ажиллагаатай танилцах хүсэлт тавихад тэр дор нь шийдэрлүүлж өгдөг, сэтгүүлчдийн ажил хөдөлмөрийг ойлгодог, хамтран ажиллахад төвэггүй хүн “Дуулга” студийн захирлаар томилогдон очсонд олон сэтгүүлч алга ташиж буй за. Хурандаа уг нь улстөрийн ажилтан. Цэргийн нэгдсэн дээд сургуулийг 1987 онд энэ мэргэжлээр дүүргэжээ. ЗХ-ний 150 дугаар ангийн захирагчийн орлогчоор ажиллаж байгаад Цэргийн музейн захирлаар томилогдон ажилласан. Музейн сан хөмрөгийн хадгалалт хамгаалалт, олон түмний хүртээл болгох тухайд багагүй зүйлийг хийсэн гэдгээр нь эдүгээ хамт олон нь үгүйлдэг юм билээ. Онцгой байдлын ерөнхий газарт ажилласан богино хугацаанд тус байгууллагыг өөрийн гэсэн музейтэй болгосон гавьяатай нэгэн.

## Мэргэжлийн бус чуулгын дарга

Мэргэжлийн бус хүн нарийн мэргэжил бүхий байгууллагыг удирдах нь ямар хор хөнөөл учруулдгийг монголчууд сүүлийн 20 гаруй жил бие сэтгэлээрээ мэдэрч буй. МАН ч энэ алдааг давтсаар байгаагийн бодит жишээ нь Цэргийн дуу бүжгийн чуулгын дарга, хурандаа Г.Золзаяа юм. Тэрбээр урлаг соёлын “А”–гүй нэгэн. ЦНДС-ийн улс төрийн ангийг дүүргэсэн. Гэхдээ сүүхээтэй эр. Хэний ч хөлд сууж чадна, аль ч намд тал алдахгүй дагаж чаддаг хурандаа. Лу.Болдыг сайдаар ажиллаж байх үед “Ардчилд үнэнч” гээд гүйж явснаа Цолмонг сайдаар томилогдонгуут “Би МАХН-д элэгтэй” хэмээн харайлгаж явсан байдаг. Цагтаа архитай тун чиг дотно нөхөрлөж явсан тэрбээр музейн дарга болмоцоо сураггүй мартаж чадсан сайн талтай. Түүний хэн болохыг сайн мэдэх чуулгын хамт олон эдүгээ ирээдүйдээ санаа зовнин нойргүй хоноцгоож байгаа гэнэ лээ. Дундговийнхон дуу хуурт сайн болохоор чуулгыг хэнээс ч илүү сайн авч явж байж ч мэдэх юм. Хүлээж суух л үлдлээ.

## Цэргүүд нь мартдаггүй дарга

Батлан хамгаалах яамны Архивын газрын даргаар томилогдсон Зулын Эрдэнэбат хурандаа Монгол Улсын шадар сайдын нөмөр нөөлөгт явдаг хүмүүсийн нэг. Бас сайд асан Сономпилын анх гаргаж ирсэн хүн нь. Тэрбээр цагтаа шадар сайдын ротын дарга нь явсан юм бол сайд асан Сономпилийг дээд сургууль төгсөн ЗХ-ний 150 дугаар ангид томилогдон очиход салаан захирагч байсан юм гэнэ лээ. Сономпил сайд ажлаа хүлээж авсан даруйд З.Эрдэнэбатыг Таван толгой дахь “Цэрэг” жуулчны баазын даргаар томилсон байдаг. Монгол хүний ёс жудаг сайхан ч юм уу. Хэн нэгийг халамжилж, ажил амьдралд нь дэм болж явахыг үүргээ юм шиг санадаг нь.

## Албан тушаалаар шагнуулсан хурандаа

Цэргийн музейн дарга, хурандаа З.Баярмагнай бас л ЦНДС-ийн улс төрийн ангийг дүүргэсэн нэгэн. Эдүгээ тэдний эрин үе ирж байгаа бололтой. Б.Бат-Эрдэнэ сайдын хийсэн томилгооны ихэнхийг улс төрийн ажилтнууд авав. Хурандаа З.Баярмагнайн хувьд яамныхаа Хяналт шалгалт, үнэлгээний газрын даргаар ажиллаж байсан болохоор музейн сан хөмрөгт хамгийн оновчтой үнэлгээг хийж, өөд татах нь гарцаагүй. Эзэмшилт газар нь жилээс жилд хумигдсаар байгаа музейг авран хамгаалах үүрэг түүнд ногдож буйг эрхэм хурандаа мэдэрч суугаа биз ээ.

## Дэлхий мэдэх хошууч генерал

Монгол Улсын Батлан хамгаалах салбар, зэвсэгт хүчнийх нь ур чадварыг дэлхий үнэлсээр байгаагийн цаана хувь хүний боловсрол, мэдлэг, ур чадвар оршдог билээ. Эл тодорхойлолтыг хүртэх эрхтэй цөөн хүний нэг нь БХИС-ийн захирал, хошууч генерал Я.Чойжамц. Манай цэнхэр дуулгатнууд олон улсын энхийг сахиулах үйл ажиллагаанд оролцох бүхий л үндэс суурийг энэ эрхэм тавьсан хэмээн цэнхэр дуулгатнууд төдийгүй зэвсэгт хүчнийхэн үнэлдэг юм билээ. Я.Чойжамц гэх автор энхийг сахиулах ажиллагаатай холбоотой олон зүйлд анхдагч гэдгээр үлдэх учиртай. Энхийг сахиулагчтай холбоотой хуулийн төсөл боловсруулахад хуулийн санаа, чиглэл, бодлого зорилтыг түүнийг тодорхойлж өгсөн гэх юм билээ. Засгийн газар, Гадаад харилцааны яамны ажлын хэсэгт багтаж, энхийг сахиулагчдыг бэлтгэх ажилд биечлэн оролцсон төдийгүй анхны багийг олон улсад илгээх ажлыг зохион байгуулсан гээд олон зүйлийг өгүүлж болно. Бас Монгол Улс НҮБ-ын мандат дор үүрэг гүйцэтгэхэд ч энэ хүний оруулсан хувь нэмэр их. Англи хэлний мэдлэг, боловсролын тухайд Монголын зэвсэгт хүчинд эдүгээ хүчин зүтгэж буй албан хаагчдаас түүний өмнө гишгэх хүн бараг л үгүй болов уу. Түүний хэн болохыг таньж, дэргэдээ шадарлуулж, ирээдүйн генералыг бэлтгэсэн хүн нь дэслэгч генерал Л.Моломжамц. Цэргийн нэгдсэн дээд сургуулийн ерөнхий цэргийн командлалын ангийг дүүргэсэн тэрбээр эдүгээ төрөлх сургуулийнхаа захирлаар ажиллаж буй нь хувь заяаны ховор тохиол болов уу. Дашрамд өгүүлэхэд, АНУ-ын Үндэсний Батлан хамгаалах их сургуулийг 2007 онд манай улсаас ганцхан хүн төгссөн нь хошууч генерал Я.Чойжамц юм билээ.

ЧУХАЛ СЭДЭВ

# Д.ОЧИРБАТ: 2020 ОН ГЭХЭД ВИРУСЫН ТАРХАЛТЫГ ТА УСТГАНА ГЭСЭН ТӨЛӨВЛӨГӨӨТЭЙ АЖИЛЛА

Э.ТУУЛ

*Монгол Улсын Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Д.Очирбаттай ярилцлаа. Тэрбээр хэдхэн хоногийн өмнө АНУ-д албан ёсны айлчлал хийсэн УИХ-ын гишүүн Г.Занданшатарын айлчлалын бүрэлдэхүүнд багтан, тус улсад айлчлахдаа олон чухал ажлуудыг амжуулаад иржээ. Төрийн нарийн бичгийн даргатай айлчлалын үеэр амжуулсан ажлынх нь талаар ярилцсанаа хүргэе.*

**-УИХ-ын гишүүн Г.Занданшатарын айлчлалын бүрэлдэхүүнд багтан АНУ-д 10 хоногийн айлчлал хийгээд ирсэн. Айлчлалын явцад Засгийн газрын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт багтсан нэлээд томоохон хөтөлбөрийн хүрээнд асуудлаа шийдээд ирсэн гэж сонслоо. Энэ талаараа яриач?**

-Монгол Улс элэгний хорт хавдрын нас баралтаараа дэлхийд тэргүүлэгч улсын тоонд ороод байна. Үүний гол шалтгаан нь С, B, D вирусын тархалт Монгол Улсад өндөр байгаатай холбоотой. Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт тусгагдсан “Элэг бүтэн Монгол” хөтөлбөрийн судалгаа, эрдэм шинжилгээний дэд хөтөлбөрийн хүрээнд хийгдсэн АНУ-ын Стэнфордын их сургууль болон Монгол Улсын эрдэмтдийн хамтарсан судалгаагаар элэгний B вирусын архаг халдвартай иргэдийн 60 орчим хувь нь элэгний D вирусын давхар халдвартай болохыг судлан тогтоосон. Энэхүү судалгааны үр дүн элэг судлалын чиглэлээр дэлхийд хамгийн нэр хүндтэй, алдарт “Хепатологи” сэтгүүлд 2016 оны арваннэгдүгээр сард гарсан. Түүнчлэн дэлхийн нэр хүндтэй “Journal of Viral Hepatites” гэдэг сэтгүүлд 2017 оны хоёрдугаар сард хэвлүүлсэн монгол эрдэмтдийн судалгааны ажлын үр дүнгээр 400 гаруй мянган хүн элэгний С, B, D вирусын архаг халдвартай тухай дурьдсан байна билээ. Элэгний архаг вирусын тархалт өндөр байгаа нь элэгний хорт хавдар, нас баралтаар Монгол Улс дэлхийд тэргүүлэхэд хүргээд байгаа юм. Ердөө гуравхан сая хүн амтай, түүнийх нь 400 гаруй мянган хүн элэгний вирусын халдвартай байна гээд бодохоор маш өндөр үзүүлэлт гарах нь аргагүй. Дээр дурьдсан вирусын халдвартай 400 гаруй мянган хүний 150 мянга нь С вирустай бол 150 мянга нь B вирустай байна. B вирустай хүмүүсийн 60 орчим хувьд нь D вирус давхар байгаа. Ерөнхийдөө элэгний D вирус нь хүний элгэнд тусдаг хепатитын вирусын хамгийн хүнд хэлбэр бөгөөд элэгний хатуурал, элэгний хорт хавдарт хамгийн хурдан хүргэдэг маш аюултай вирус юм. Тиймээс МАН болон шинээр байгуулагдсан Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт Эрүүл мэндийн салбарын хүрээнд авч хэрэгжүүлэх арга хэмжээнд “Элэгний хатуурал, хорт хавдраас сэргийлэх “Элэг бүтэн Монгол” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ” хэмээн тусгасан. Үүнийхээ хүрээнд Монгол Улсын Засгийн газар “Элэг бүтэн Монгол” хөтөлбөрийг хэрэгжүүлж, 2020 он гэхэд вирусын тархалтыг таслан зогсоож, устгана гэсэн төлөвлөгөөтэй ажиллаж байна. Одоо байгаа 400 гаруй мянган вирустай хүмүүсийг эмчилнэ. Элэгний вирусын өвчлөлийн талаар дорвитой арга хэмжээ авсан улс орны тоонд орно гээд үүрэг амлалт авчихсан. Тэгээд би сая УИХ-ын гишүүн Г.Занданшатарын айлчлалын бүрэлдэхүүнд багтаж, АНУ-д айлчлаад ирлээ. Айлчлалын үеэр АНУ-ын алдарт Стэнфордын их сургууль дээр эрдэмтэдтэй уулзалт хийж, илтгэл тавилаа. Стэнфордын их сургуулийн хамгийн анхны байгууламжуудын нэг болох Синна холлын Окимото хурлын танхимд болсон энэхүү уулзалтад таван орны төрийн нарийн бичгийн даргатай зэрэгцэх албан тушаалтнууд болон тус сургуулийн элэг, эрүүл мэндийн чиглэлийн доктор, профессор, том том эрдэмтэд оролцлоо. Энэхүү уулзалт, зөвлөгөөнд миний бие Монгол Улсын Засгийн газрын хэрэгжүүлж байгаа “Элэг бүтэн Монгол” хөтөлбөр, элэгний С вирусын эмчилгээний үр дүнгийн талаар илтгэл тавьсан. Илтгэлдээ Засгийн газрын мөрийн хөтөлбөрт тусгаад хууль болгож, батлаад иргэддээ эм авахад нь эрүүл мэндийн даатгалаас хөнгөлөлт үзүүлж байгааг дурьдсан. Ерөнхийдөө С вирустай иргэдийн 98 хувь нь эдгэрэлттэй байгааг сонсоод тэдгээр эрдэмтэд үнэхээр сайшаалтай хандаж байсан. Монгол Улсын Засгийн газар эрүүл мэндийн салбартаа үнэхээр том ажлуудыг хийж байна. Жишиг улс болоход үнэхээр дөхсөн байна. Эрдэмтэд нь Монголд очиж, элэгний вирусын эсрэг ийм сайн туршлагатай явж байгаа, элэгний эмчилгээг дэмжиж, хууль болгон баталж байгаа, эм авах гэж буй иргэддээ эрүүл мэндийн даатгалын сангаас 23.4 тэрбум төгрөгийн хөнгөлөлтийг үзүүлж, тэдэнд тулгарч буй санхүүгийн хүндрэл, бэрхшээлийг хөнгөлж байгааг сонсоод АНУ-ын эрдэмтэд маш өндөр сэтгэгдэлтэй байгаагаа хэлж байсан. Мөн гурван сая хүнтэй улс хүмүүсээ оношлогоонд хамруулчихдаг, төр засгаас нь эрүүл мэндийн салбарынхаа асуудлыг мөрийн хөтөлбөртөө тусгадаг ийм улс оронтой хамтарч ажиллахад таатай байна гэсэн.

**-Тэгэхээр цаашид элэгний вирусыг устгах тал дээр хамтарч ажиллах саналууд нэлээд иржээ дээ?**

-Айлчлалын үеэр АНУ-ын Калифорни мужийн Фостер хотод байрлах “Гилеад Сайнс” компанийн төв байранд тус компанийн Корпораци болон Эрүүл мэндийн асуудал хариуцсан тэргүүн дэд ерөнхийлөгч Грейг Альтон, Хүртээмж хөтөлбөр болон хөгжиж буй орнуудын зах зээлийг хариуцсан дэд ерөнхийлөгч Клифорд Самуэль, тус хөтөлбөрийн стратегийг хариуцсан дэд захирал Ахмед Афифи, үйл ажиллагаа хариуцсан захирал Элизабет Циликунос нартай уулзлаа. Грейг Альтон бол олон улсын хэмжээнд хэрэгжиж буй хүртээмж хөтөлбөрийн нөлөө бүхий албан тушаалтан бөгөөд түүний санаачилсан ажлын хүрээнд Монгол Улсад софосбувир/ ледипасфир эм асар хямдралтай үнээр орж ирэх үндэс суурь тавигдсан юм. Хуучин бол элэгний С, B вирустай хүн маш өндөр үнэтэй тариа хийлгэдэг. Тэр тариагаа зургаан сарын турш хийлгэдэг байлаа. Тэр тариаг хийлгэж байх хугацаандаа үс нь унадаг, бие нь хөхөрдөг, турдаг, эцдэг, бүр тариагаа хийлгэж байхдаа амиа хорлодог байсан бол эдүгээ шал өөр болчихсон. Харвони эмийг уугаад л С вирусаас салах боломжтой болсон. Энэ эмийг оруулж ирж байгаа хамтын ажиллагаатай гадаадын улс орнуудын буянаар Монголын олон мянган хүн С вирусаасаа салж байгаа. С вирустай хүмүүсийн эм уугаад эдгэж байгаа нь 98 хувьтай гарсан. Дэлхийн жишгээсээ бүр давсан. Дээрээс нь манай Засгийн газар бүх эмэнд нь 85 ам.долларын хөнгөлөлт үзүүлж байгаа. Энэ бол үнэхээр том ажил. Уулзалтын хүрээнд бид “Гилеад Сайнс” компанитай гурван чиглэлээр хамтарч ажиллах санал тавьсан. Тодруулбал, элэгний С вирусын халдвартай эрүүл мэндийн салбарын эмч, ажилтнуудын дунд уг вирусын голомтыг устгах, тэднийг эмчилж эдгээх талаар санал тавьсан. Учир нь эрүүл мэндийн салбарт ажилладаг ажилтнууд маань ажлаа хийж байх үедээ хүний цустай хутгалдаад, вирусын халдвар авсан байдаг. Одоогоор элэгний вирусын халдвартай 48 мянган ажилтан, албан хаагчид байгаагаас 5000 нь элэгний С вирусын архаг халдвартай байна. Тиймээс эрүүл мэндийн салбарын ажилтан, албан хаагчдыг эрүүлжүүлэх зорилгоор 5000 хүн тун буюу 15 мянган хайрцаг эмийг хандивлах, дэмжлэг үзүүлээч гэдэг хүсэлтийг тавьсан. Бидний хүсэлтийг нааштайгаар хүлээн авч, шийдвэрлэж өгөхөөр болсон. Ингээд бидний явсан ажлын эхлэл амжилттай байж, эрүүл мэндийн салбарынхаа 5000 хүнийг аврах, эрүүлжүүлэх, эмчлэх тал дээр том ажил бүтээж ирлээ. Учир нь эмч, эмнэлгийн ажилтнууд маань эрүүл саруул байж эргээд иргэддээ тусламж үзүүлж, эмчилнэ шүү дээ. Тэгэхээр бид энэ салбарынхаа асуудлыг шийдэх тал дээр том алхам хийлээ гэж үзэж байна. Мөн Монгол Улсын ЭМЯ-наас нийт хүн амыг B, С вирусын шинжилгээнд хамруулах тал дээр “Гилеад Сайнс” компанитай хамтран ажиллах талаар санал тавьсан. Энэ чиглэлээр Амстердамд болох Европын холбооны Элэгний эмгэг судлалын холбооны хурал, Олон улсын элэгний конгрессийн үеэр дахин уулзалт хийж, хамтын ажиллагаагаа илүү тодруулахаар болсон. Үүнээс гадна Монгол Улс элэгний С вирусын эсрэг өндөр үйлчлэлтэй софосбувир/ ледипасфир эмийг эх орондоо үйлдвэрлэх боломжийн талаар харилцан санал солилцоход энэхүү эмийг үйлдвэрлэх эрх авсан компаниудтай нарийвчлан ярилцаад эргэж хариу хэлнэ гэдгээ Грейг Альтон илэрхийлсэн. Ийнхүү дээр дурьдсан хамтын ажиллагаануудыг хэрэгжүүлье гэсэн Монголын талын хүсэлтийг “Гилеад Сайнс” компанийн тал нааштайгаар хүлээн авсан. Тиймээс монгол хүний эрүүл мэндийг хамгаалах тал дээр онцгой анхаарч, өндөр үйлчлэлтэй эмийг Монголд авчирч, дэмжлэг туслалцаа үзүүлж, олон хүнийг аварч байгаа буянтай үйлсэд нь талархаж байгаагаа илэрхийлэхийн зэрэгцээ Грейг Альтоныг Монголд албан ёсоор айлчлахыг урьсан.

> ...Хуучин бол элэгний С, B вирустай хүн маш өндөр үнэтэй тариа хийлгэдэг. Тэр тариагаа зургаан сарын турш хийлгэдэг байлаа. Тэр тариаг хийлгэж байх хугацаандаа үс нь унадаг, бие нь хөхөрдөг, турдаг, эцдэг, бүр тариагаа хийлгэж байхдаа амиа хорлодог байсан бол эдүгээ шал өөр болчихсон. Харвони эмийг уугаад л С вирусаас салах боломжтой болсон. Энэ эмийг оруулж ирж байгаа хамтын ажиллагаатай гадаадын улс орнуудын буянаар Монголын олон мянган хүн С вирусаасаа салж байгаа. С вирустай хүмүүсийн эм уугаад эдгэж байгаа нь 98 хувьтай гарсан. Дэлхийн жишгээсээ бүр давсан...

**-Стэнфордын их сургуулийн эрдэмтэн элэгний хорт хавдрыг эмчлэх асуудал дээр дэвшилттэй алхам хийсэн гэж сонссон. Та айлчлалынхаа үеэр тэр хүнтэй уулзаж чадсан уу?**

-Засгийн газрын мөрийн хөтөлбөрт орсон “Элэг бүтэн Монгол” хөтөлбөрийн хүрээнд элэгний хорт хавдар, хатуурал, нас баралтыг эрс бууруулах, бүр устгах зорилт тавьсан. Түүнчлэн элэгний B,С вирусын эсрэг маш өндөр үр дүнтэй эмчилгээнүүд Монголын эрүүл мэндийн салбарын эмчилгээний практикт нэвтэрсэн хэдий ч элэгний хорт хавдрын эсрэг эмчилгээ хангалттай бус байгаа. Өөрөөр хэлбэл, элэгний анхдагч хорт хавдраар Монголд жилд дунджаар

Аймгаас мэдээлж байна

ХОВД АЙМАГ



## Ерөнхий сайд гавьяат эдийн засагч А.Шайзаныд зочиллоо

Ерөнхий сайд Ж.Эрдэнэбат Ховд аймагт албаны хүмүүсийн хамт хүрэлцэн ирэхэд аймгийн Нисэх онгоцны буудал дээр тус аймгийн удирдлагууд,иргэд, хөдөлмөрчдийн төлөөлөл хүлээн авлаа. Энэ өдөр Ховдоос Баян-Өлгийд ажиллах байсан боловч Баян-Өлгий аймагт цас үргэлжлэн орж ажлын айлчлалд өөрчлөлт орж Ховд аймагт бүтэн өдөр ажиллахаар боллоо. Ерөнхий сайдын хамт ХЗДХЯ-ны сайд УИХ-ын гишүүн С.Бямбацогт, Эрчим хүчний сайд П.Ганхүү нарыг Ард Аюушийн талбайд Цэргийн хүрээний хүндэт харуул жагсаж угтсаны дараа аймгийн ЗДТГ-ын ёслол хүндэтгэлийн өргөөнд аймгийн засаг дарга Д.Галсандондог хүлээн авч уулзан, нийгэм эдийн засгийн танилцуулга хийж, харилцан ярилцлаа. Уулзалтын дараа Ерөнхий сайд албаны хүмүүсийн хамт Ховд аймгийн Ховд суманд айлчилж, казак түмний наурызын баярын бөхийн барилдаан тус сумын Соёлын төвд болж байх үеэр хүрэлцэн очлоо. Казак түмний үндэсний баяр хаврын баяраа тэмдэглэж байгаа казах иргэд үндэсний хувцсаар гоён баяр хүргэж угтан авлаа. Ерөнхий сайд Ховд сумын ард иргэдэд Монгол Улсын Засгийн газрын нэрийн өмнөөс наурыз баярын мэндчилгээ дэвшүүлж, Ховд сумын Дунд ус багийн иргэн Монгол Улсын гавьяат эдийн засагч А.Шайзан гуайнд зочиллоо. Гавьяат эдийн засагч А.Шайзан тус аймагт удирдах албайн тушаал эрхэлж байсан, тэргүүний сэхээтнүүдийн төлөөлөл юм байна.

ДАРХАН-УУЛ АЙМАГ

## “Эрүүл Дарханчууд” дэд хөтөлбөрийн ажлын зураглалыг гаргалаа

Дархан-Уул аймгийн төр, хувийн хэвшлийн эрүүл мэндийн салбарын бүх шатны 70 гаруй удирдах ажилтан оролцсон зөвлөгөөн хоёр өдөр үргэлжилж өндөрлөлөө. Зөвлөгөөний нээлтэд УИХ-ын гишүүн Д.Хаянхярваа, Б.Баттөмөр аймгийн ИТХ-ын дарга Г.Эрдэнэбат, аймгийн Засаг даргын орлогч А.Түвшинбат, Нийгмийн Бодлогын Хэлтсийн дарга Н.Цасчихэр нар болон тус салбарын эмч, ажиллагсад оролцлоо. Эхний өдрийн зөвлөлгөөнд аймгийн Эрүүл Мэндийн газрын дарга Б.Батцэнгэл болон хэлтсийн дарга, мэргэжилтнүүд “Эрүүл мэндийн салбарын бодлого”, “Нийгмийн эрүүл мэнд, санхүү төлөвлөлт, хяналт үнэлгээ”, “Эмнэлгийн тусламж үйлчилгээ”, “Эмийн аюулгүй байдал”, “Салбарын шинэ технологи, инноваци”, “Хувийн хэвшлийн тусламж үйлчилгээ”-ний талаар мэдээлэл хийж илтгэл тавив. Зөвлөгөөнөөр “Эрүүл Дарханчууд” дэд хөтөлбөрийн найман зорилтын хүрээнд 2017-2026 онуудад хэрэгжүүлэх гол ажлын зураглалыг зөвлөлдөж гаргалаа. Зөвлөгөөний дараагийн өдөр нь “Имако Консалтинг” институтын захирал Д.Лхагвадулам, багш Б.Итгэлт нар удирдах ажилтнуудад “Шинэ эринд байгууллагыг хэрхэн шинэчлэх вэ”, “Шинэ цагийн удирдлагын эмидж”, “Бүтээлч сэтгэлгээний загварчлал”, “Удирдлага, байгууллага дахь зэрэг харилцааг үйлдвэрлэгч” зэрэг сэдвээр сургалт явууллаа. Энэ үеэр тус аймгийн ЭМГ-ийн газрын дарга Б.Батцэнгэл “Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний тухай хууль, “Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлого” зэрэг хууль, эрх зүй шинээр бүрдсэнээр эрүүл мэндийн тэргүүлэх чиглэлийг “Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ” гэж тодорхойлсон.

Энэ үйлчилгээнд хүн амын эрүүл мэндийн байдал, түүнд нөлөөлөх хүчин зүйлийг тандан судлаж хянах, эрүүл мэндийг дэмжин хамгаалж өвчин эмгэгээс урьдчилан сэргийлж хүн амд эрүүл мэндийн боловсрол олгоход салбаруудын оролцоо чухал үүрэгтэй. Эрүүл мэндийн үйлчилгээ, улсын болон орон нутгийн хэмжээнд баримталж байгаа бодлого чиглэлээр зөвлөлдөж удирдах ажилтнуудын арга барилыг чадавхжуулахад энэ удаагийн хоёр өдрийн сургалтын зорилго оршиж байна” гэв.

СЭЛЭНГЭ АЙМАГ

## Шаардлагад тохирохгүй ус унд ахуйдаа хэрэглэж байна гэв

Сэлэнгэ аймгийн нийт сумдын 43.6 хувь нь эрүүл ахуйн шаардлагад тохирохгүй ус унд ахуйдаа хэрэглэж байгаа нь судалгаагаар илэрчээ. Сэлэнгэ аймгийн УЦУОША-ны Байгаль орчины шинжилгээний лабораториос аймгийн хэмжээнд ажиллаж байгаа худгуудын усанд гидрохимийн шинжилгээ хийж, дүгнэлт гарган ажиллаж байна. Үүнд сумдад байгаа инженерийн хийцтэй болон иргэдийн энгийн хийцтэй, мөн шинээр гаргасан худгууд хамрагджээ. Тус лаборатори судалгааны дүнгээ сүүлийн таван жилийн дундажаар тооцоолон дүгнэлт гаргасан аж. Тухайлбал судалгаанд хамрагдсан нийт худгийн усны чанарыг унд ахуйн хэрэглээний усны стандарттай харьцуулж үзсэн байна. Ингэхэд Сант, Хөтөл, Ерөө, Хүдэр, Алтанбулаг, Мандал, Цагааннуур, Орхонтуул зэрэг сумдын худгийн ус эрдэсжилт ихтэй.

Харин Алтанбулаг, Хүдэр, Ерөө, Мандал сумдын иргэдийн худгийн ус хатуу устай байжээ. Тодруулбал судалгаанд хамрагдсан нийт худгийн усны 3.6 хувь нь кальци, 7.3 хувь нь магни, 10.9 хувь нь фторын хэмжээ их байгаа нь илэрчээ. Энэ нь эрүүл ахуйн шаардагад нийцэхгүй устай худаг ашиглаж байна гэсэн үг юм. Иргэдийн эзэмшилд байгаа худгийн ихэнхи хувь нь энгийн гар аргаар, 7–12 метрийн гүнээс гаргасан худгууд байдаг байна. Ийм худгийн ус нь гүний бус хөрсний ус байдаг аж. Мөн зарим сумд 20-иос дээш жил ашигласан, хугацаа нь хэтэрсэн инженерийн хийцтэй худгаас усаа авч байгаа зэрэг нь усны чанарт ихээхэн нөлөөлж байгаа гэдгийг мэргэжлийн хүн хэллээ.

Иймээс Сэлэнгэ аймаг цаашид сумдын усны чанарыг сайжруулах, технологийн асуудлыг шийдвэрлэх, мөн ундны устай холбоотой өвчлөлийг тодорхой сум, багт гүнзгийрүүлэн судлах зайлшгүй шаардлага гарч байгаа аж. Ингэснээр хүн амынхаа эрүүл мэндийг хамгаалах чухал алхам болох ажээ. Тус лаборатори нь энэхүү шинжилгээний ажлаа 2008 оноос хойш тогтмол хийж байгаа гэнэ.

## ЧУХАЛ СЭДЭВ

# ...АСЛАН ЗОГСООЖ, ...Ж БАЙНА



Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

1800-2000 орчим хүн оношлогдож, эдгээрийн 80 орчим хувь нь жил хүрэхгүй хугацаанд өвчнийхөө улмаас нас барж байгаа тун харамсалтай тоо баримт байгаа. Ийм учраас бид элэгний B, D вирусын эсрэг эмчилгээг шинээр нээн илрүүлсэн Стэнфордын их сургуулийн Анагаахын их сургуулийн профессор, дэлхийн нэрт эрдэмтэн Жефри Гленнтэй уулзаж, ярилцсан. Тэрбээр хамт ажилладаг эрдэмтэдтэйгээ хамтран Айгер био Фармацевтикал компанийг байгуулсан бөгөөд түүний шинээр нээсэн элэгний хорт хавдрын эсрэг эмчилгээ маш амжилттай явагдаж байгаа гэж ярьж байсан. Тодруулбал, Турк улсын Анкарагийн их сургуульд түүний шинэ эмчилгээгээр элэгний хорт хавдартай хүмүүсийг эмчилсэн нь үр дүнгээ өгч байгааг дурьдаж байсан. Тиймээс Монгол Улсад энэхүү шинэ эмчилгээг нэн даруй нэвтрүүлж, элэгний хорт хавдраар өвчилсөн хүмүүстээ боломж олгох талаар профессор Жефритэй ярилцаж, түүний лабораторитой танилцсан. Уулзалтын үр дүнд Монгол Улсад энэхүү шинэ эмчилгээг хурдан хугацаанд нэвтрүүлэхээр санал нэгдэж, хамтран ажиллах талаар илүү нухацтай ярилцах нь зүйтэй хэмээн тогтсон. Профессор Жефри ирэх дөрөвдүгээр сарын 03-нд манай улсад айлчилна. Тэр үеэрээ элэгний хорт хавдрын эсрэг шинэ эмчилгээний талаар Засгийн газар, УИХ-тай албан ёсоор, тодорхой чиглэлүүдээр хамтран ажиллах талаар ярилцах юм. Үүнээс гадна бид Айгер био Фармацевтикал компанийн ерөнхийлөгч, доктор Дэвид А.Коритой уулзаж, тус компанийн хөгжүүлж буй Сарсар буюу Ланофармид эмийн клиникийн судалгааг Монгол Улсад оруулах нэн тэргүүний шаардлага байгааг дуулгаж, санал тавьсан. Доктор Дэвид А.Кори АНУ-ын Үндэсний эрүүл мэндийн хүрээлэн, БНГУ-ын Хановирын их сургуулийн Анагаах ухааны хүрээлэн, Турк улсын Анкарагийн их сургууль зэрэг газруудад явагдаж буй клиникийн судалгааг танилцуулж, Олон улсын дөрөв дэх төвийг Монгол Улсад нээхээр хурдацтай ажиллаж байгаагаа бидэнд мэдээлсэн. АНУ-ын Хүнс, эмийн агентлаг буюу FDA энэхүү судалгааны протоколыг хянаж байгаа бөгөөд энэхүү судалгааны үр дүн тун удахгүй гарч, Монголд Олон улсын дөрөв дэх төв нээгдэж, элэгний B, D вирусын давхар халдвартай иргэд маань энэхүү төсөл хөтөлбөрт хамрагдах боломж ойртлоо. Манай улсын B, D вирусын давхар халдвартай иргэд энэхүү судалгааны талаар маш сайн мэддэг юм байна лээ. Энэ асуудлын талаар ярилцаж, зөвшилцлөө гэхэд маш олон хүн утсаар ярьж, хэзээ ирэхийг нь асууж байсан.

**-Таны яриаг сонсч байхад 15-аас дээш насны бүх хүнийг үзлэг шинжилгээнд хамруулах тухай дурьдагдлаа. Тэгэхээр Монгол Улсын нийт хүн амыг хамарсан нэлээд том ажил болох нь дээ?**

-Тийм ээ, “Элэг бүтэн Монгол” хөтөлбөрийнхөө хүрээнд бид эрт илрүүлгийн ажлыг хийхээр болсон. Одоогийн байдлаар бид элэгний вирустай хүмүүсийг 400-430 мянга гэж тооцож байгаа боловч яг үнэндээ үүнээс ч их байхыг үгүйсгэхгүй. Тиймээс 15 наснаас дээш насны хүмүүсийг эрт илрүүлэгт хамруулж, албан ёсны шинжилгээгээр тогтоох ёстой гэдэг шийдэлд хүрсэн юм. Засгийн газраас элэгний С вирустай хүмүүст 23.4 тэрбум төгрөгийн хөнгөлөлт үзүүлээд, эмийг нь хямдруулаад өгчихөж байна. Түүнчлэн энэ ажилд зөвхөн төрийг хараад суугаад байж болохгүй. Тиймээс төрийн болон ТББ, олон нийтийн оролцоог хангах тал дээр олон талт арга хэмжээг авахаар төлөвлөөд байгаа. Бид сая АНУ-ын Эрүүл мэндийн яамны Гадаад харилцаа, хамтын ажиллагаа хариуцсан хүмүүстэй уулзалт хийсэн. Энэ үеэр ЭМЯ-ны Олон улсын хамтын ажиллагаа хариуцсан дэд нарийн бичгийн дарга Стив Смит судалгаанд суурилсан бодлого гаргаж, хөтөлбөрийнхөө үр дүнг хэмжиж байгаа нь маш зөв зүйтэй хэмээн сайшааж, энэ чиглэлд хамтран ажиллах, дэмжлэг үзүүлэхээ илэрхийлсэн. Үүнээс гадна эрүүл мэндийн салбарын хүний нөөцийг нэмэгдүүлэх, сургах, харилцан туршлага солилцох тал дээр ч хамтарч ажиллахаар болсон.

**-Сүүлийн үед С вирусын эсрэг 3D эмчилгээ гарсан гэсэн мэдээлэл гарах болсон. Энэ талаар тодруулахгүй юу?**

-Бид сая айлчлалын хүрээнд АНУ-ын томоохон эмийн үйлдвэрлэгч компаниудын нэг болох “Аббвие” компанийнхантай уулзсан. Тус компани нь элэгний С вирусын эсрэг 3D буюу “Викера пак” эмчилгээг зохион бүтээсэн, дэлхийн 176 оронд салбартай, дэлхий даяар 28 мянган хүнийг ажлын байраар хангадаг шинжлэх ухаанд үндэслэгдсэн дэлхийн хамгийн том биофармасептикал компаниудын нэг юм. Энэхүү компанийн гаргасан 3D эмчилгээ нь С вирусын эсрэг маш өндөр үр дүнтэй бөгөөд энэхүү эмчилгээнд хамрагдсан хүмүүсийн 98-аас дээш хувь нь гурван сарын дотор бүрэн эдгэрдэг гэсэн. Бид тус компанийн Элэгний С вирусын эрүүл мэндийн асуудал хариуцсан захирал Фернандо Татч болон албаны бусад хүмүүстэй уулзсан. Энэхүү эмчилгээг Монголд нэвтрүүлэх, бусад үйл ажиллагаанууд дээр хамтрах хүсэлтээ тавьсан. Түүнчлэн Амстердам хотноо болох хурлын үеэр дахин уулзаж, ярилцах байх. Үүнээс гадна бид “Женентох” компанийн дэд ерөнхийлөгч Карло Брагнотой уулзаж, хавдар судлалын чиглэлээр хамтарч ажиллах талаар санал солилцсон. Түүнчлэн Монгол Улсын эрүүл мэндийн салбарт хэрэгжиж буй “Цахим эрүүл мэнд” төслийн талаар “Аллейд Телесис” компанийн төлөөлөгчидтэй уулзаж, тэдний туршлагаас судаллаа. Энэ компани нь Япон улсын 3000 гаруй эмнэлгээс 1000 орчмынх нь мэдээлэл технологийн сүлжээг хангаж нийлүүлж, сүлжээг байнгын үйл ажиллагаатай байлгахыг бүрэн хариуцаж ажилладаг олон жилийн туршлагатай юм билээ. Тус компанийн ТУЗ-ийн дарга, ерөнхий захирал Такаёши Ошима Монгол Улсын эрүүл мэндийн салбарт цахим эрүүл мэндийн системийн хүрээнд хамтран ажиллах боломжтой гэдгээ илэрхийлсэн.

**-Ирэх сард Нидерландын Амстердам хотноо ирэх сард “Олон улсын элэгний конгресс” болох юм билээ. Энэ хуралд манайхаас оролцох уу?**

-“Олон улсын элэгний конгресс”-д маш олон орны төлөөлөгчид оролцоно. Их том үйл ажиллагаа болох юм билээ. Энэхүү үйл ажиллагаанд Монгол Улсыг оролцож, улсынхаа ололт амжилттын талаар, Засгийн газрын “Элэг бүтэн Монгол” хөтөлбөрийн талаар, хийж хэрэгжүүлж байгаа томоохон ажлуудынхаа талаар илтгэл тавиач гэдэг урилгыг өгсөн. Тиймээс Монгол Улсаа төлөөлж, оролцох нь зөв гэж бодож байна.

## Аймгаас мэдээлж байна

### ДОРНОГОВЬ АЙМАГ

## Гэр бүлийн хүчирхийлэлэй тэмцэх хуулийг сурталчиллаа



Дорноговь аймгийн Цагдаагийн газар болон Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлтэй хамтран Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийг сурталчлах ажлын хүрээнд сургалт зохион байгууллаа. Сургалтыг Хууль сахиулах их сургуулийн Нийгмийн ухааны сургуулийн Эрх зүйн онолын тэнхимийн ахлах багш, цагдаагийн ахмад, докторант О.Отгонтуяа удирдан явуулжээ. Сургалтад нутгийн захиргааны болон хууль хяналтын байгууллагын 40 гаруй алба хаагч болон 105 гаруй иргэн оролцжээ. Мөн сургалтын үеэр төрийн албан хаагчдад хуулиар олгогдсон эрх, үүргийн талаар, төрийн бус байгууллагын төлөөлөл болон иргэдэд гэр бүлийн хүчирхийллийн талаархи ойлголт, иргэний үүргээ хэрхэн биелүүлэх талаар мэдээлэл өгсөн юм. Харин Цагдаагийн газрын алба хаагчдад адулын зэргийн болон нөхцөл байдлын үнэлгээг хэрхэн хийх талаар онол, практик хэрэглээний дадал олгох, сургууль, цэцэрлэгийн 80 гаруй багш, сурган хүмүүжүүлэгч болон нийгмийн ажилтнуудад хүүхэд хамгааллын хууль болон хүүхэдтэй хэрхэн харилцах талаар сургалт, мэдээлэл хийсэн байна.

### ДАРХАН-УУЛ АЙМАГ

## “Төр, нийгмийн түншлэл-2017” зөвлөгөөн Дархан-Уул аймагт болно

Дархан-Уул аймгийн Засаг даргын Тамгын газраас энэ сарын 24-нд “Төр, нийгмийн түншлэл-2017” зөвлөгөөн зохион байгуулахаар болжээ. Энэхүү зөвлөгөөн анх удаа зохион байгуулагдаж байгаа бөгөөд тус аймгийн Засаг даргын 2017 оны үйл ажиллагааны хөтөлбөр, 2017-2020 онд аймгийн нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх зорилтын хүрээнд төр, хувийн хэшлийн хамтын ажиллагааг өргөжүүлэх, төрийн бодлого боловсруулахад иргэн, ТББ-ын саналыг тусгаж, оролцоог нэмэгдүүлэх зорилготой юм байна. Мөн “Төр, нийгмийн түншлэл-2017” зөвлөгөөний үеэр Дархан-Уул аймгийн Засаг даргын мөрийн хөтөлбөрт ирэх жилүүдэд хийж хэрэгжүүлэхээр тусгасан бодлого, шийдвэр, төсөл, хөтөлбөрүүдийн талаарх мэдээллийг оролцогчдод танилцуулах бөгөөд зөвлөгөөнөөс гарсан үр дүн, шийдвэрийн төслийг танилцуулж, батлах гэнэ. Дашрамд сонирхуулахад, өнөөдөр зөвлөгөөнтэй холбогдуулан аймгийн Иргэний танхимтай хамтран “Нээлттэй хэлэлцүүлэг” зохион байгуулж, иргэд, төрийн бус байгууллагуудын саналыг авах юм байна.

### БАЯНХОНГОР АЙМАГ

## Хот хоорондын зорчигч тээврийг түр хязгаарлалаа



Үргэлжлэн орж буй цастай холбогдуулан Баянхонгор аймгийн Онцгой комисс хуралдаж, энэ сарын 22-24-ний өдрийн 0:.00 цаг хүртэл хот хооронд болон хөдөө орон нутагт тээврийн хэрэгслийн хөдөлгөөний зогсоох шийдвэр гаргалаа. Өнөөдрийн байдлаар Улаанбаатараас Ховд чиглэл, Баян-Өлгийгөөс Улаанбаатар чиглэлд явж байсан хоёр автобусны 100 шахам хүн Баянхонгор аймагт саатаад байна. Зорчигч хөдөлгөөнийг нээх хүртэл тус автобуснууд болон аймгийн хуваарьт автобуснуудыг явуулахгүй байхаар болжээ. Энэ сарын 24-ныг хүртэлх хугацаанд Улаанбаатар явахаар Автотээврийн газарт билет бичүүлсэн байсан хүмүүс буцаалт хийлгэхэд ямар нэгэн шимтгэлгүй үйлчилж байгаа бөгөөд буцаагаагүй тохиолдолд зам нээснээс хойшхи хугацаанд тус билетээрээ зорчиж болох юм байна.

MMINFO.
Тал нутгийн цахим мэдээлэл

# ДЭЛХИЙ

## "Севол"-ыг татаж гаргана



Гурван жилийн өмнө Өмнөд Солонгосын баруун өмнөд эрэгт осолдон живсэн "Севол" гатлага онгоцыг татаж гаргах бэлтгэл ажил хийгдэж дууссаныг Өмнөд Солонгосын Далайн тээвэр, загас агнуурын яам мэдэгдлээ.

Зорчигч тээврийн "Севол" гатлага онгоц 2014 оны дөрөвдүгээр сарын 16-нд Чэжү арал орохоор явах замдаа осолдож, живсэн билээ. Ослын улмаас 304 хүн амиа алдсан бөгөөд тэдний ихэнх нь 15-19 насны ахлах ангийн сурагчид байсан юм. Түүнчлэн есөн хүн сураггүй алга болсон билээ.

Живсэн онгоцыг далайн гүнээс татаж гаргах ажлыг дөрөвдүгээр сарын 5 хүртэлх аль нэг өдөр хийх бөгөөд Мугпу боомт хот руу 87 км чирч явахаар төлөвлөж байгаа аж.

Татаж гаргах ажил нь цаг агаарын байдлаас ихээхэн шалтгаалах гэнэ. Өмнө нь хэд хэдэн удаа татаж гаргах ажиллагаа хойшилж байсан нь цаг агаарын тааламжгүй байдалтай холбоотой байсан гэдгийг мөн албаныхан онцолжээ. Өмнөд Солонгосын Далайн тээвэр, загас агнуурын яам 145 метр урттай, 6.825 тонн жинтэй "Севол" гатлага онгоцыг татаж гаргах ажлыг "Шанхай Сэлвэж" компанитай хамтран гүйцэтгэх юм байна.



# ОЛОН УЛС БРАЗИЛ МАХНААС ТАТГАЛЗАЖ ЭХЭЛЛЭЭ

**Үргэлжлэл.**
**Түрүүч нь I нүүрт**

Өнгөрөгч мягмар гарагт гэхэд Бразилын үхрийн мах, махан бүтээгдэхүүн борлуулах хамгийн том зах зээл гэгддэг Хонконг, Мексик бүтээгдэхүүний импортдоо хориг тавьсан бол Япон ч гэсэн Бразилд шалгагдаж буй 21 аж ахуй нэгжийн махыг улс руугаа импортлохгүй байх арга хэмжээ авчээ. Хонконгийн Хүнсний аюулгүй байдлын төв "Бразилд боловсруулсан мах махан бүтээгдэхүүний чанарт эргэлзээтэй асуудал гарсантай холбоотойгоор тус улсаас хөлдүү болон хөлдөөсөн мах, махан бүтээгдэхүүн, тахиа шувууны махны импортыг түр хугацаагаар зогсоох арга хэмжээ авсан" хэмээн мэдэгдсэн байна.

Статистик мэдээллээр, Хонконг 2016 онд 718 сая ам.долларын үхрийн мах импортолсон байх бөгөөд энэ нь улс, хийгээд бүс нутгийн хэмжээнд хамгийн том зах зээл болж байдаг ажээ. Гэвч, Хонконг импортоо зогсоосон нь Бразилын махны үйлдвэрлэл, түүнээс олох орлогод том цохилж болж байгааг "франц пресс" мэдээлж байна.

Харин Мексикийн тухайд мөн мягмар гарагийн шөнө Бразилийн Засгийн газраас тус улсад үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн эрүүл ахуйн шаардлага хангасан, чанартай, аюулгүй гэдгийг шинжлэх ухааны төвшинд баталж, нотлохыг шаардсаны зэрэгцээ тахиа, шувууны махны импортод хориг тавьж буйгаа зарлалаа. Аргентин ч тус улсын бүтээгдэхүүний чанар, стандартад тавих хяналт шалгалтаа чангатгах арга хэмжээ авахаа мэдэгдээд байгаа юм.

Бразил махнаас татгалзаж буй улсын жагсаалтыг Япон үргэлжлүүлж, хууль хяналтын байгууллагад шалгагдаж байгаа махны чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг 21 аж ахуй нэгжийн бүтээгдэхүүний импортод хориг тавилаа. Бразилд боловсруулсан тахиа, шувууны мах махан бүтээгдэхүүний импортын гол худалдан авагчдын нэг нь Япон бөгөөд зах зээлийн хувьд гуравдугаарт эрэмбэлэгддэг байна. Японы хувьд жилдээ 72 сая ам.долларын импорт хийдэг ажээ. Бразилын эрүүл ахуйн байцаагчид улсын томоохон мах махан бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдээс авлига авч, эрүүл ахуйн шаардлага хангахгүй, чанаргүй ялзарч муудсан бүтээгдэхүүнийг зах зээлд нийлүүлж байсан нь хууль хяналтын байгууллагын шалгалтын явцад тогтоогдсон байдаг. Үүнээс үүдэн өмнө нь БНХАУ, ЕХ-ны улсууд зэрэг Бразилын хувьд махны экспортын голлох хувийг эзлэх улсууд бүтээгдэхүүний импортоо тодорхойгүй хугацаагаар зогсоох шийдвэр гаргаж эхэлсэн билээ. Мөн БНСУ, Өмнөд Америк, Чили ч гэсэн импортоо зогсоожээ. Дашрамд дурьдахад, Бразилын Холбооны цагдаагийн газар хугацаа нь дууссан мах борлуулсан40гаруйтохиолдлыг илрүүлэн шалгаж байгаа аж. Тэдний дунд JBS болон BRF гэсэн хоёр том компани багтсан байх бөгөөд менежерүүд эрүүл ахуйн байцаагчдад хахууль өгч, чанарын баталгааны гэрчилгээ авч байсан байна. Мах үйлдвэрлэгч компаниуд бүтээгдэхүүнийхээ чанарыг сайн гэж харагдуулахын тулд химийн бодисууд ашиглаж байжээ.

## Пак Гын Хег 14 цаг байцаажээ

Авлига, албан тушаалаа урвуулан ашигласан гэх мэт хэд хэдэн үндэслэлээр буруутгагдаж буй БНСУ-ын Ерөнхийлөгч асан Пак Гын Хе Сөүлийн Прокурорын газарт очиж мэдүүлэг өгсөн билээ.Улмаар энэ үйл ажиллагаа удтал сунжирсны эцэст Пак өчигдөр өглөөний 06.55 цагт прокурорын байрыг орхижээ. Мэдүүлэг өгөх ажиллагаа мягмар гарагийн 09.35 цагт эхэлсэн юм. Тэгвэл түүнийг байцаах үйл ажиллагаа бүтэн 14 цагийн турш үргэлжилж, оройн 23.40 цагт дууссан боловч, баримт бичиг баталгаажуулах зэрэг ажил үргэлжилсний улмаас үндсэндээ 21 цаг гаруй хугацаанд Прокурорын газарт саатсан тухай орон нутгийн мэдээллийн агентлагууд дамжууллаа. Пак Гын Хе найз Чой Сун Шилийн хамт БНСУ-ын томоохон корпорацийн нэг Самсунгаас 43.3 тэрбум воны авлига авсан гэх мэт нийт 13 хэрэгт буруутгагдаж байгаа юм.

Гэхдээ Пак, Чой нар гэм буруутай гэдгээ хүлээн зөвшөөрөхгүй байгаа. Харин цаашид Ерөнхийлөгч асан Пакийг дахин байцаалтад дуудагдах, цагдан хорих тухай шүүхийн шийдвэр гаргуулах эсэхэд прокурорын газар үгүйсгэсэн хариулт өгсөн байна. Прокурорууд байцаалтын талаар тодорхой тайлбар хийгээгүй ч, "Пак мөрдөн байцаалтын явцад хангалттай хариулт өгсөн" гэжээ.


## АЖЛЫН БАЙРНЫ ЗАР

Дараах шаардлагуудыг бүрэн хангасан хүнийг МАРКЕТИНГИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ-ын бүрэн цагаар ажиллах ажлын байранд өргөдлөө гаргахыг Энэтхэгийн Элчин сайдын яам урьж байна:-

1. Худалдаа /Эдийн засаг/ Бизнесийн удирдлагаар Мастерын зэрэгтэй.
2. Өндөр хэмжээний бичгийн орчуулгын болон ойлгох ур чадвар бүхий Англи, Монгол хэл (ярианы болон бичгийн аль алиний нь)-ийг өндөр түвшинд эзэмшсэн.
3. Компьютерийн маш сайн мэдлэгтэй, фейсбүүк, твиттер зэрэг нийгмийн харилцааны хэрэгсэл ашиглах, хэрэглэх чадвартай.
4. 25 нас бүрэн хүрсэн.
5. Удирдах түвшний ажлын туршлагатай, бие даасан худалдааны илтгэл бэлтгэх, бизнесийн хамт олонтой харилцан маркетингийн судалгаа хийх чадвар чухал тал болно.
6. Элчин сайдын яамд/ Олон талт хамтын ажиллагаатай байгууллага зэрэг Дипломат байгууллагад ажилласан туршлагатай.
7. Энэтхэг эсвэл аль нэг англи хэлтэй оронд боловсрол эзэмшсэн болон/ эсвэл ажилласан туршлагатай бол давуу тал болно.

Зөвхөн шаардлага хангасан өргөдөл гаргагчийг Шалгалт болон Ярилцлагат урих болно.

**Өргөдлөө товч намтрын хамт 2017-03-31(Баасан гараг)-ний 1700 цагт багтаан доорх э-мейлээр илгээнэ үү: admn.ulaan@mea.gov.in.**

**АНХААР: УЛААНБААТАР ДАХЬ ЭНЭТХЭГИЙН ЭЛЧИН САЙДЫН ЯАМ ЯМАР НЭГ ТАЙЛБАРГҮЙ ЯМАРЧ ӨРГӨДЛӨӨС ТАТГАЛЗАХ ЭРХТЭЙ.**



## "ЭРЭЭНЦАВ" ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН АНХААРАЛД

"Эрээнцав" ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2017 оны 04 дүгээр сарын 29-ний бямба гарагийн 11:00 цагт Улаанбаатар хотод Баянзүрх дүүрэг, 6-р хороо, Энхтайваны өргөн чөлөө, 75/1 байр, 10-р давхарын хурлын танхимд хуралдана.

**Хурлаар дараах асуудлыг хэлэлцэнэ:**

1. Компанийн 2016 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлт;
2. Компаний тухай хуулийн 62.1.4-д заасны дагуу компаний хэлбэрийг өөрчлөх эсэх асуудлыг хэлэлцэх.

Хувьцаа эзэмшигчид брокер, дилерийн компани, хурал зохион байгуулах комисстой холбогдож, хурлаар хэлэлцэх асуудал болон гарах шийдвэрийн төсөл, түүнтэй холбогдох баримт бичигтэй танилцаж болно. Хурал зохион байгуулах комиссын гишүүдтэй Даваагаас Баасан гаригуудад 9-18 цагийн хооронд дор бичигдсэн хаяг, утсаар холбогдох боломжтой.

Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдөр **2017 оны 04 дугаар сарын 10-ны өдөр** байна.

Хурал зохион байгуулах комиссын даргаар М.Жалавдорж, гишүүдээр Д.Солонго, нар ажиллана.

**Эрээнцав ХК**
**Улаанбаатар хотод Баянзүрх дүүрэг, 6-р хороо,**
**Энхтайваны өргөн чөлөө, 75/1 байр, 10-р давхар**
**Харилцах утас: 7601-9999; 9911-8738**
**G_odgrl@yahoo.com**



## АЖЛЫН БАЙРНЫ ЗАР

Дараах шаардлагуудыг бүрэн хангасан хүний НИЙГМИЙН АЖИЛТАН бүрэн цагаар ажиллах ажлын байранд өргөдлөө гаргахыг Энэтхэгийн Элчин сайдын яам урьж байна:-

1. Бакалаврын зэрэгтэй. Мастерын зэрэгтэй бол давуу тал болно.
2. Өндөр хэмжээний бичгийн орчуулгын болон ойлгох ур чадвар бүхий Англи, Монгол хэл (ярианы болон бичгийн аль алиний нь)-ийг өндөр түвшинд эзэмшсэн.
3. Компьютерийн маш сайн мэдлэгтэй, фейсбүүк, твиттер зэрэг нийгмийн харилцааны хэрэгсэл ашиглах, хэрэглэх чадвартай.
4. 21 нас бүрэн хүрсэн.
5. Элчин сайдын яам/Олон талт хамтын ажиллагаатай байгууллага зэрэг Дипломат байгууллагат ажилласан туршлагатай.
6. Энэтхэг эсвэл аль нэг англи хэлтэй оронд боловсрол эзэмшсэн болон/ эсвэл ажилласан туршлагатай бол давуу тал болно.

Зөвхөн шаардлага хангасан өргөдөл гаргагчийг Шалгалт болон Ярилцлагат урих болно.

**Өргөдлөө товч намтрын хамт 2017-03-31(Баасан гараг)-ний 1700 цагт багтаан доорх э-мейлээр илгээнэ үү: admn.ulaan@mea.gov.in.**

**АНХААР: УЛААНБААТАР ДАХЬ ЭНЭТХЭГИЙН ЭЛЧИН САЙДЫН ЯАМ ЯМАР НЭГ ТАЙЛБАРГҮЙ ЯМАРЧ ӨРГӨДЛӨӨС ТАТГАЛЗАХ ЭРХТЭЙ.**



## АЖЛЫН БАЙРНЫ ЗАР

Дараах шаардлагуудыг бүрэн хангасан хүнийг ХУДАЛДАА/ МАРКЕТИНГИЙН ТУСЛАХ АЖИЛТАН бүрэн цагаар ажиллах ажлын байранд өргөдлөө гаргахыг Энэтхэгийн Элчин сайдын яам урьж байна:-

1. Худалдаа /Эдийн засаг/ Бизнесийн удирдлагаар Бакалаврын зэрэгтэй. Мастерын зэрэгтэй бол давуу тал болно.
2. Өндөр хэмжээний бичгийн орчуулгын болон ойлгох ур чадвар бүхий Англи, Монгол хэл (ярианы болон бичгийн аль алиний нь)-ийг өндөр түвшинд эзэмшсэн.
3. Компьютерийн маш сайн мэдлэгтэй, фейсбүүк, твиттер зэрэг нийгмийн харилцааны хэрэгсэл ашиглах, хэрэглэх чадвартай.
4. 21 нас бүрэн хүрсэн.
5. Маркетингийн туршлагатай, худалдааны илтгэл бэлтгэх ур чадвар чухал болно.
6. Ажлын туршлагатай, ялангуяа Элчин сайдын яамд/ Олон талт хамтын ажиллагаатай байгууллага зэрэг Дипломат байгууллагад ажилласан туршлагатай.
7. Энэтхэг эсвэл аль нэг англи хэлтэй оронд боловсрол эзэмшсэн болон/ эсвэл ажилласан туршлагатай бол давуу тал болно.

Зөвхөн шаардлага хангасан өргөдөл гаргагчийг Шалгалт болон Ярилцлагат урих болно.

**Өргөдлөө товч намтрын хамт 2017-03-31(Баасан гараг)-ний 1700 цагт багтаан доорх э-мейлээр илгээнэ үү: admn.ulaan@mea.gov.in.**

**АНХААР: УЛААНБААТАР ДАХЬ ЭНЭТХЭГИЙН ЭЛЧИН САЙДЫН ЯАМ ЯМАР НЭГ ТАЙЛБАРГҮЙ ЯМАРЧ ӨРГӨДЛӨӨС ТАТГАЛЗАХ ЭРХТЭЙ.**

# ЦАГ ҮЕ

МЭДЭЭЛЭЛ

# АЮУЛТАЙ АЧАА ТЭЭВЭРЛЭГЧДИЙГ ЧАДАВХИЖУУЛАХ СУРГАЛТ БОЛЛОО




**Төгсгөл.**
**Түрүүч нь IV нүүрт**

Сүүлийн үед уул уурхай, ашигт малтмалын тээвэрлэлт ихсэж байгаатай холбогдуулан аюултай ачаа тээвэрлэлт нэлээд ихэссэн. Мөн аюултай ачаа тээвэрлэлт ихэссэнээс болж зөрчлүүд гарч байгаа. Тиймээс аж ахуйн нэгжүүддээ нэгдсэн ойлголт өгөх зорилгоор энэхүү сургалтыг зохион байгууллаа.

**-Аюултай тээвэрлэлтэд ямар бүтээгдэхүүн, ачаа багтдаг юм бэ?**

-Аюултай ачаа тээвэрлэлтэд тэсэрч, дэлбэрэх бодис, химийн бодис зэрэг ордог. Эдгээр ачааг тээвэрлэхийг аюултай ачаа тээвэрлэлт гэж нэрлэж байгаа юм.

**-Одоогийн байдлаар аюултай ачаа тээвэрлэдэг хэчнээн аж ахуйн нэгж байна вэ?**

-Манай Автотээврийн үндэсний төвтэй гэрээтэй 40 орчим байгууллага бий. Бүртгэлтэй аж ахуйн нэгжийн төлөөллүүд энэхүү сургалтад хамрагдаж байгаа.

**-Сүүлийн үед аюултай ачаа тээвэрлэлтэд зөрчил гарч байна гэлээ. Аж ахуйн нэгжүүд ямар зөрчлүүдийг ихэвчлэн гаргаж байна вэ?**

-Аюултай ачааг тээвэрлэх тусгай журам байдаг. Энэ журмын дагуу аюултай ачааг тээвэрлэх ёстой. Аж ахуйн нэгжүүд ихэвчлэн тээвэрлэлтийн журмыг баримтлаагүй зэрэг зөрчлийг гаргадаг. Тухайлбал, тэсэрч дэлбэрэх бодис ачсан машин тодорхой заасан хурднаас хэтрүүлэхгүй явах ёстой. Мөн цуваанд орж явах, хяналттай байх ёстой юм. Зарим байгууллагууд энэ мэтчилэн зөрчлийг гаргаж байгаа учраас энэ сургалтыг зохион байгуулж байна.

**-Аюултай ачааг тээвэрлэх тусгай журам байдаг гэсэн. Энэ журмын хэрэгжилтэд хяналт тавьж чадаж байна уу. Хөдөө орон нутагт тээвэрлэлт хийж байгаа шүү дээ?**

-Албан байгууллагууд манай байгууллагатай гэрээ хийсэн бол тодорхой маршрутын дагуу тээвэрлэлт хийх ёстой байдаг. Мөн байршил тогтоох төхөөрөмжийн хяналтад орох ёстой гэдэг шаардлагыг тавьдаг. Үүний дагуу байршил тогтоох төхөөрөмжид холбогдож тээвэрлэлт гүйцэтгэдэг. Түүнээс гадна бид Автотээврийн үндэсний төвийн орон нутаг дахь салбарын улсын байцаагч нараар дамжуулан хяналт тавьж байгаа.

...Аюултай ачааг тээвэрлэх тусгай журам байдаг. Энэ журмын дагуу аюултай ачааг тээвэрлэх ёстой. Аж ахуйн нэгжүүд ихэвчлэн тээвэрлэлтийн журмыг баримтлаагүй зэрэг зөрчлийг гаргадаг...

### Б.Должинсүрэн: 40 орчим тээврийн хэрэгсэл байршил тогтоох төхөөрөмжтэй

*/АТҮТ-ийн Хөдөлгөөний хяналтын хэлтсийн мэргэжилтэн/*

-Манай АТҮТ-ийн Хөдөлгөөний хяналтын хэлтсийн байршил тогтоох төхөөрөмжид аюултай ачаа тээвэрлэгч 16 аж ахуйн нэгжийн 40 орчим тээврийн хэрэгсэл бүртгэлтэй байдаг. Өөрөөр хэлбэл, 40 орчим тээврийн хэрэгсэлд байршил тогтоох төхөөрөмж суурилуулан нэгдсэн системд холбон ажиллаж байгаа юм. Wialon системд холбогдсоноор жолооч нар интернэтийн тусламжтайгаар гар утсаа ашиглан бүх төрлийн мэдээллийг авах боломжтой. Тухайлбал, хурдны тайлан, газар зүйн байршлын тайлан болон тээврийн хэрэгслийн хурдны мэдээллийг өдөр, сар, жилээр авч болдог. Энэхүү систем нь хэд хэдэн тохиолдол гарахад программд анхааруулга өгдөг. Тухайн жолоочийн тээврийн хэрэгсэл хурд хэтрүүлсэн, заасан хугацаанаас олон хоног мэдээлэл дамжуулаагүй тохиолдолд программ дуут дохио өгч мэдээллийг дамжуулдаг байгаа. Мөн маш олон төрлийн газрын зургийг нэг дор харах боломжтой. Энэ мэтчилэн аюултай ачаа тээвэрлэгч аж ахуйн нэгжийн жолооч нарын аюулгүй ажиллагааг хангадаг.

### Ч.Болд: Мэргэшсэн жолоочийн сургалт явуулах эрхтэй 13 байгууллага бий

*/АТҮТ-ийн Мэргэшсэн жолоочийн тасгийн мэргэжилтэн/*

-Манайд мэргэшсэн жолоочийн сургалт явуулах зөвшөөрөлтэй 13 байгууллага байдаг. 2010 оноос 2017 оны I улирал хүртэлх хугацаанд аюултай ачаа болон овор ихтэй, урт ачаа тээвэрлэх мэргэшил дээшлүүлсэн жолоочийн судалгаанаас харахад, өнөөдрийн байдлаар нийт 1227 жолооч сургалтад сууж, мэргэшсэн байна. Тодруулбал, 2010 онд 62, 2015 онд 472, 2016 онд 389 жолооч мэргэшсэн. Харин 2017 оны I улиралд 49 жолооч мэргэшсэн жолоочийн сургалтад суусан. Одоогийн байдлаар мэргэшсэн жолоочийг аюултай ачаа болон овор ихтэй, урт, хүнд ачаа тээвэр, улс хоорондын ачаа зорчигч тээвэр, жуулчин тээвэр, нийтийн зорчигч тээвэр гэсэн чиглэлд мэргэжил дээшлүүлэх сургалтад бэлтгэж байгаа.

### Х.Эрдэнэчулуун: Ачаа тээвэрлэлтэд гурван байгууллага хамтарсан шалгалт хийсэн

*/НМХГ-ын улсын ахлах байцаагч/*

-Төрийн хяналт, шалгалтын тухай хууль 2003 онд УИХ-аар батлагдсан. Түүнээс хойш хоёр удаа нэмэлт өөрчлөлт орсон байдаг. Ер нь төрийн хяналт шалгалт иргэдийн эрүүл, аюулгүй байдлыг хангах үүрэгтэй. Ажил үйлчилгээ явуулж буй аж ахуйн нэгж, иргэдийн хуулийн хэрэгжилтийн төвшинг хангахад энэ хууль чиглэж байгаа юм. Манай улсад төрийн хяналт шалгалт төлөвлөгөөт, төлөвлөгөөт бус, гүйцэтгэлийн гэсэн гурван төрөлтэй. Төлөвлөгөөт хяналт шалгалтыг хэрэгжүүлэхдээ эрсдлийн үнэлгээ хийж, эрсдлийг бууруулах чиглэлээр ажилладаг. Үүнд энэ хуулийг гол чиглэлээ болгодог. Өнгөрсөн сард автотээврийн ачаа тээвэрлэдэг аж ахуйн нэгжүүдэд гурван байгууллагын хамтарсан шалгалт явагдсан.

МЭДЭЭ МЭДЭЭЛЭЛ

## Нүүрсний үнэ өнгөрсөн оны мөн үеийнхээс 105 хувиар өсчээ

Н.БОЛД

Монгол банкнаас өчигдөр цаг үеийн асуудлаар мэдээлэл хийлээ. Энэ үеэр зарим статистик мэдээллийг Монголбанкны судалгаа, статистикийн газрын захирал Д.Ган-Очир өглөө. Тэрбээр нүүрсний үнэ өсч, худалдааны тэнцэл ашигтай гарч байгаа талаар мэдээлсэн юм. Тэрбээр "Нийт гадаад худалдааны эргэлт энэ оны хоёрдугаар сарын байдлаар 1.3 тэрбум ам.долларт хүрсэн. Үүнийг экспорт, импортоор нь салгавал 825 сая ам.долларыг экспорт, үлдсэнийг импорт эзэлж байгаа. Ингэснээр нийт худалдааны тэнцэл 334 сая ам.долларын ашигтай гарсан.

Ингэж ашигтай гарахад нөлөөлсөн гол хүчин зүйл бол экспортын өсөлт. Экспортын үнийн өсөлт дотроо нүүрсний үнэ нэмэгдсэн нь илүү нөлөөлж байна. Нүүрсний экспорт өнгөрсөн оны мөн үеэс 280.1 сая ам.доллараар өссөн. Үүнээс гадна үнийн өсөлт бас нөлөөлж байгаа. Нүүрсний үнэ өнгөрсөн оны мөн үеэс 105 хувиар өссөн. Харин өнгөрсөн сартай харьцуулахад, 10 хувиар өслөө. Одоогийн байдлаар нэг тонн нүүрсийг дунджаар 72 ам.доллараар экспортолж байна" хэмээн мэдээллээ.

## Гуравдугаар сарын эхэнд 259 зээлдэгчид 14.1 тэрбум төгрөгийн ипотекийн зээл олгожээ

Монголбанкны Ерөнхийлөгчийн 2016 оны аравдугаар сарын 25-ны өдрийн А-295 дугаар тушаалаар "Орон сууцны ипотекийн санхүүжилтийн журам"-ыг шинэчлэн баталсан бөгөөд тус журмын дагуу Монголбанк орон сууцны ипотекийн санхүүжилтийг хэвийн олгож байгаа ажээ.

Тэгвэл 2017 оны хоёрдугаар сард Монголбанкнаас "Орон сууцны ипотекийн санхүүжилтийн тогтвортой тогтолцоог бий болгох хөтөлбөр"-ийн хүрээнд нийт 396 зээлдэгчдэд 24.1 тэрбум төгрөгийн зээлийн эх үүсвэрийг олгосон байна. Харин гуравдугаар сарын эхний ээлжийн санхүүжилтээр нийт 259 зээлдэгчдэд 14.1 тэрбум төгрөгийн зээлийн эх үүсвэрийг олгожээ.

**"ХАР ХОРУМ ПРОПЕРТИЙС" ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН АНХААРАЛД**

"Хар хорум пропертийс" ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2017 оны 4-р сарын 28-ны өдрийн 12.00 цагт УБ, ЧД, 3-р хороо, Пийс Тауэрын 904 тоот, Алтантрэйд ХХКомпанийн байранд болно.

Хувьцаа эзэмшигчдийн бүртгэлийн өдөр: 2017-04-09

**Хэлэлцэх асуудлууд:**

1. Компанийн 2016 оны үйл ажиллагааны тайланг хэлэлцэх;
2. Компанийн 2016 оны санхүүгийн тайланг хэлэлцэх;

*Хурлын материалтай 2017 оны 04-р сарын 27-ний өдрөөс 9-17 цагийн хооронд Алтантрэйд ХХК-ийн байранд ирж танилцах боломжтой.*

**Холбоо барих: Хурал зохион байгуулах комисс Э.Сод-эрдэнэ, Э.Шагдарсүрэн**
**Утас: 88225425**

**ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИСС**

ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ

# Д.НАЦАГДОРЖ ХАМБЫН ТУХАЙ ӨГҮҮЛЭХ БАРИМТАТ КИНО ИРЭХ ЗУН НЭЭЛТЭЭ ХИЙНЭ

**Төгсгөл.**
**Түрүүч нь I нүүрт**

Энэхүү кино нь Австралийн уугуул иргэний тухай өгүүлдэг бөгөөд Олон улсын кино наадмаас өндөр үнэлгээ авсан аж. Харин хоёр дахь цуврал нь уламжлалт анагаах ухааны доктор Д.Нацагдорж хамбын амьдрал, хийж хэрэгжүүлсэн ажил зэргийнх нь талаар өгүүлэх юм байна. Мөн Хамба ламтанаар дамжуулан монголчуудын уудам тал нутаг, зэрлэг онгон байгаль, өвлийн хүнд ширүүн нөхцөлийг дүрслэхээс гадна, өв соёл, зан заншил, ард түмнийх нь өвөрмөц хэм маягийг энэхүү уран бүтээлээрээ харуулах ажээ. Хоёр дахь цуврал болсон энэхүү уран бүтээлийн Монгол дахь хэсгийн зураг авалт өнгөрсөн сарын 25-наас эхэлсэн бөгөөд энэ сарын 20-ны өдөр сүүлчийн дүрсээ авсан байна. Харин өнөөдөр кино багийнхан Лондон хотыг зорих бөгөөд тэнд киноны үлдсэн хэсгийн зургийг авч гүйцээх аж. Хамба ламтан Д.Нацагдорж Лондон хотод Уламжлалт анагаах ухааны чиглэлээр олон жил ажиллаж, аг тарины ёсыг хүмүүст хүртээж байсан учраас киноны сүүлийн хэсэг Их Британи нийслэл Лондон хотод авахаар болсон байна. Хэвлэлийн бага хурлын үеэр Хамба лам Д.Нацагдорж "Дэлхийн соён гэгээрүүлэгчдийн талаар баримтат кино хийдэг өндөр мэргэжлийн кино уран бүтээлчид Монголд ажиллаад сар гаруй хугацаа өнгөрлөө. Үүний учир гэвээс, нэг сарын хугацаанд миний юу хийдэг, ямар ажил эрхэлдэг талаар бодитой уран бүтээл гаргахыг зорьсон юм.

Энэ кинонд зөвхөн миний амьдрал ахуйгаас гадна, Монголын соёл, бурхны шашин, боловсрол, эрүүл мэндийн төвшин зэргийг харуулах юм. Мөн уламжлалт анагаах ухаан, бидний өв уламжлалыг энэ киногоор дамжин дэлхий дахинаа таниулах юм. Тиймээс миний зүгээс энэ уран бүтээлд маш их ач холбогдол өгсөн. Кино амархан бүтдэггүй гэдгийг нэг сарын хугацаанд ойлгож авсан. Олон газруудаар явж зураг авалт хийсэн ч энэхүү кинонд нэг ч эвлүүлэг хийхгүй юм билээ. Нэг сарын хугацаанд миний юуг хэрхэн хийдгийг ямар ч жүжиглэлтгүй, зохиомжгүйгээр шууд хүргэж байгаа юм. Ингэж хийснээрээ олон шүүмжлэлд өртөж магадгүй" хэмээв. Харин тус киноны найруулагч Бэнжамин Жонс "Энэхүү цуврал баримтат кинонд орон орны онцлог хүмүүсийг сонгон авч байгаа. Харин Монгол орныг, мөн Д.Нацагдорж хамбыг энэ кинонд зөвлөх продюссерээр ажиллаж байгаа Константин Палвидис санал болгож, түүний тухай анх ярьсан юм.

Хамба ламтны хийж хэрэгжүүлсэн болоод одоо хийж байгаа олон ажлуудыг нь сонсоод бишрэх, хүндэтгэх сэтгэл өөрийн эрхгүй төрсөн. Бас дараагийн цувралынхаа гол дүрийн олчихлоо гэж бодогдсон. Кино бүтээх үйл явц маш хурдан өрнөж байсан. 2016 оны аравдугаар сард киноны гол дүрийг олоод, арваннэгдүгээр сард түүнтэй хамтарч ажиллах саналаа явуулж, киноны бэлтгэл ажилдаа орсон юм. Оны сүүлчээр бид Д.Нацагдорж хамбатай ирж уулзаж, төлөвлөгөөгөө гаргаж, 2017 оны хоёрдугаар сард киноны эхний дүрсийг бичнэ хэмээн тохирцгоосон. Тэгэхэд Хамба лам "Та нар ч эд хүйтэн байхад ирэх нь дээ" хэмээн хэлж байсан ч



Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

бидний төсөөлснөөс ч илүү аймаар байсан.

Гэсэн ч бид шантралгүйгээр, олон сайхан сэтгэлт хүмүүсийнхээ ачаар зураг авалтаа саадгүй дуусгасан юм. Монголчууд үнэхээр сайхан сэтгэлтэй, тусч ард түмэн гэдгийг зураг авалтын үеэр дэндүү их мэдэрсэн. Бас сэтгэн бодох хурд, хамтын ажиллагаа, дасан зохицох чадвар үнэхээр сайтай хүмүүс гэдгийг хамтарч ажилласан монгол хүмүүсээсээ харж байсан" гэж хэлж байлаа. Тэд "Дэлхийн Соён гэгээрүүлэгчид" цуврал киноныхоо эхлэл болгон хийсэн Австралийн уугуул иргэдийн тухай киногоороо хоёр дахь уран бүтээлийнхээ санхүүжилтыг бүрэн олж чадсан байна. Учир нь түүний хийсэн уран бүтээл олон амжилт, магтаал, маргааныг араасаа дагуулсан аж. Харин энэ удаагийн киноны зураг авалтын ихэнх хэсгийг Д.Нацагдорж хамбын төрсөн нутаг Завхан аймгийн Цагаанчулуут суманд хийжээ. Тэгвэл тус киноны зураглаачаар Герри Васбэнпер ажиллаж байгаа юм. Тэрбээр бидний сайн мэдэх "Бөгжний эзэн", "Оддын дайн", "Gravity" зэрэг олон киноны зураглаачаар ажиллаж байсан туршлагатай нэгэн билээ. Тэрбээр хэлэхдээ "Би олон кинонд зураглаачаар ажиллаж байсан. Олон ч газруудаар явж байлаа.

Гэхдээ Монгол оронд ирж зураг авалт хийнэ гэдэг үнэхээр гайхалтай хэрэг. Нэг ч машины мөр гарч байгаагүй онгон байгальд ирнэ гэдэг зураглаач хүний хувьд алдаж болохгүй сайхан завшаан. Мөн Монгол хүмүүсийн царайны төрх камерийн дурангаар их сайхан харагддаг. Үнэхээр өвөрмөц төрхтэй ард түмэн. Мэргэжлийн үүднээс ярихад, эдгээр зүйлс надад маш том боломж болсон. Харин хувь хүн талаасаа харвал, монголчууд нээлттэй, чөлөөтэй сэтгэж чаддаг юм шиг санагдсан. Зураг авалтын үеэр камерийн зай дуусч, хүндрэл гарч байсан. Тэгэхэд цэнэггүй зайг маань хэдэхэн цагийн дараа яаж ийгээд л цэнэглээд араас аваад ирдэг. Тийм л мундаг, тусч хүмүүс шиг санагдаж байсан" хэмээв. Хамба лам Д.Нацагдоржийн тухай хийж буй энэ киног дуусмагц зургадугаар сарын үед нээлтийг нь хийхээр төлөвлөж байгаа ажээ. Найруулагч Бэнжамин Жонс энэхүү уран бүтээлээ Монголд тэр дундаа Завхан аймагт нээхээс гадна, олон улсын кино наадмуудад хүч үзэх төлөвлөгөөтэй байгаа юм байна. Тэрбээр өмнө нь Энэтхэгийн нүүдэлчин Sikh омгийн тухай "The Nihang", Бүгд Найрамдах Куба Улсын алдарт жазз хөгжимчний тухай "Jose Louis Cortez" гэх зэрэг олон баримтат кинонууд бүтээж байжээ. Харин хамгийн их амжилт дагуулсан уран бүтээл нь Мексик улсад бүтээсэн "The Huichols" хэмээх баримтат кино ажээ. Энэхүү кино нь ууланд аж төрдөг бөө мөргөлтөн, анчин, фермерийн аж ахуй эхрэлдэг омгийн тухай өгүүлдэг юм байна.

# МЭДЭЭЛЭЛ

## ЭРХЭМ ЗАХИАЛАГЧ ТА “МОНГОЛ ШУУДАН” КОМПАНИД ХЭВЛЭЛЭЭ ЗАХИАЛНА УУ!

### 2017 ОНЫ II УЛИРЛЫН ХЭВЛЭЛ ЗАХИАЛГА СУМДАД 03-Р САРЫН 25-НЫГ ХҮРТЭЛ, УЛААНБААТАР ХОТ БОЛОН АЙМГИЙН ТӨВҮҮДЭД 03-Р САРЫН 29-ИЙГ /НЭМЭЛТ ЗАХИАЛГА 4-Р САРЫН 01-НЭЭС 4-Р САРЫН 25-НЫГ/ ХҮРТЭЛ ЯВАГДАНА

Хэвлэл захиалгын мөнгийг Улаанбаатар хотод “Монгол Шуудан” Төрийн банкны 100000139702 тоот дансанд, бусад аймаг, хот, сум, суурин газруудад тус тусын банкны салбар дахь тухайн аймгийн шуудангийн газрын хэвлэлийн харилцах дансанд тушааж холбогдох тооцоог хийнэ.

**“МОНГОЛ ШУУДАН” ХК**

**УТАС/ФАКС: 70078916, 70078977, ШУУДАН ЛАВЛАХ: 1800-1613**
**ДАРААХЬ ХЭВЛЭЛҮҮД РЕДАКЦИАС ГАРААГҮЙ ТУЛ БУЦААН ТООЦОО ХИЙНЭ ҮҮ!**

| Д/Д | ИНДЕКС | ХЭВЛЭЛИЙН НЭР | УЛИРАЛ |
|---|---|---|---|
| 1 | 100943 | АРДЧИЛАЛ /8 ДУГААР/ | 4-Р УЛИРАЛ |
| 2 | 101570 | ӨНӨӨДРИЙН ТОЙМ | 4-Р УЛИРАЛ |
| 3 | 200114 | ДЭЭД ШҮҮХИЙН МЭДЭЭЛЭЛ | 4-Р УЛИРАЛ |
| 4 | 200205 | ГЭГЭЭРЛИЙН МЭДЭЭЛЭЛ | 4-Р УЛИРАЛ |
| 5 | 200449 | ЭРҮҮЛ МЭНД ИНЭЭМСЭГЛЭЛ | 4-Р УЛИРАЛ |
| 6 | 200747 | АНГЛИ ХЭЛ | 4-Р УЛИРАЛ |
| 7 | 200952 | СТРАТЕГИ СУДЛАЛ | 4-Р УЛИРАЛ |
| 8 | 202140 | ШИНЭ ЕРТӨНЦ | 4-Р УЛИРАЛ |
| 9 | 286206 | ТАЙЛАГДАШГҮЙ НУУЦ | 4-Р УЛИРАЛ |

### 1. ӨДӨР ТУТМЫН СОНИН

| Индекс | ХЭВЛЭЛИЙН НЭР | Улирал | | Нэмэлт | |
|---|---|---|---|---|---|
| | | Дугаар | Үнэ | Дугаар | Үнэ |
| 100757 | МОНГОЛЫН МЭДЭЭ | 64 | 22400 | 44 | 19800 |
| 102108 | ЗАСГИЙН ГАЗРЫН МЭДЭЭ+Financial Times | 64 | 30000 | 44 | 21000 |
| 100943 | АРДЧИЛАЛ | 64 | 18000 | 44 | 16000 |
| 100774 | ЗУУНЫ МЭДЭЭ | 65 | 17500 | 43 | 12000 |
| 100004 | МОНГОЛЫН ҮНЭН | 64 | 15000 | 42 | 10000 |
| 101545 | ӨГЛӨӨНИЙ СОНИН | 64 | 20000 | 45 | 17000 |
| 100816 | ӨДРИЙН СОНИН | 64-66 | 19600 | 44 | 13600 |
| 100518 | ӨНӨӨДӨР + /Ням гариг амралтын дугаар/ | 75 | 20900 | 52 | 14500 |
| 105182 | ӨНӨӨДӨР + UB POST | 75+36 | 88800 | 52+26 | 56200 |
| 114876 | УЛС ТӨРИЙН ТОЙМ | 60 | 18000 | 44 | 15000 |
| 101361 | ҮНДЭСНИЙ МЭДЭЭ | 61 | 18000 | 45 | 13000 |
| 101606 | ҮНДЭСНИЙ ШУУДАН /зууны шуудан/ | 64 | 20000 | 44 | 14000 |

### 2. ГУРАВ ХОНОГ ТУТМЫН СОНИН

| Индекс | ХЭВЛЭЛИЙН НЭР | Улирал | | Нэмэлт | |
|---|---|---|---|---|---|
| | | Дугаар | Үнэ | Дугаар | Үнэ |
| 100673 | ШУУРХАЙ ЗАР /өдрийн шуудангаар хүргэгдэнэ/ | 23 | 34500 | 17 | 25500 |
| 100501 | ЗАР МЭДЭЭ СУРТАЛЧИЛГАА /өдрийн шуудангаар хүргэгдэнэ/ | 24 | 36000 | 17 | 25500 |
| 100537 | UB POST /Өнгөт, 12 нүүр, англи хэлээр/ | 36 | 68900 | 26 | 43700 |

### 3. ДОЛОО ХОНОГ ТУТМЫН СОНИН

| Индекс | ХЭВЛЭЛИЙН НЭР | Улирал | | Нэмэлт | |
|---|---|---|---|---|---|
| | | Дугаар | Үнэ | Дугаар | Үнэ |
| 100335 | БИЗНЕС ТАЙМС | 12 | 12000 | 8 | 8000 |
| 100029 | ГАН ЗАМ | 13 | 6900 | 9 | 4800 |
| 101268 | МОНГОЛ ЦУШИН | 13 | 12000 | 9 | 9000 |
| 100070 | MONGOL MESSENGER /МОНГОЛ ЭЛЧ/ | 13 | 12000 | 9 | 9000 |
| 100702 | МОНГОЛЫН МЭДЭЭ /Хятад хэлээр/ | 13 | 12000 | 9 | 9000 |
| 100184 | НОВОСТИ МОНГОЛИИ | 13 | 12000 | 9 | 9000 |
| 101119 | OPEN DOOR /НЭЭЛТТЭЙ ХААЛГА/ | 12 | 13000 | 8 | 9000 |
| 100018 | СОЁМБО | 13 | 5000 | 9 | 3000 |
| 100459 | СЭРҮҮЛЭГ | 12 | 6000 | 8 | 5000 |
| 101688 | УЛААНБААТАРЫН СОНИН | 12 | 11000 | 8 | 7200 |
| 100011 | ХӨДӨЛМӨР | 12 | 6600 | 8 | 4400 |
| 100178 | ХҮМҮҮН БИЧИГ | 12 | 3000 | 8 | 2000 |

### 4. АРАВ ХОНОГ ТУТМЫН СОНИН

| Индекс | ХЭВЛЭЛИЙН НЭР | Улирал | | Нэмэлт | |
|---|---|---|---|---|---|
| | | Дугаар | Үнэ | Дугаар | Үнэ |
| 100752 | БОЛСОН ЯВДАЛ | 9 | 13500 | 6 | 9000 |
| 100161 | БӨХ | 9 | 7200 | 6 | 4800 |
| 101175 | МОНГОЛЧУУДЫН АМЬДРАЛ | 9 | 6000 | 6 | 5000 |
| 100013 | МОНГОЛЫН ХӨДӨӨ | 6 | 6000 | 4 | 4000 |
| 100645 | НОЦТОЙ МЭДЭЭ | 9 | 13500 | 6 | 9000 |
| 101478 | ОДОО ЦАГ | 6 | 6600 | 3 | 3300 |
| 100912 | САНХҮҮГИЙН МЭДЭЭ | 9 | 5400 | 6 | 3600 |
| 103086 | УЛААН ОДХОН-ахмад дайчдын хэвлэл | 9 | 6000 | 6 | 4000 |
| 100012 | УТГА ЗОХИОЛ, УРЛАГ | 9 | 5000 | 6 | 4000 |
| 100474 | ҮГИЙН СҮЛЖЭЭ | 10 | 8000 | 6 | 4800 |
| 159918 | ХОРИОТОЙ БҮС | 7 | 7700 | 4 | 4400 |
| 100229 | ХӨХ ТОЛБО | 9 | 4500 | 6 | 3000 |
| 101665 | ЭХ ОРНЫ МАНАА | 9 | 5000 | 6 | 3500 |

### 5. АРВАН ДӨРӨВ ХОНОГ ТУТМЫН СОНИН

| Индекс | ХЭВЛЭЛИЙН НЭР | Улирал | | Нэмэлт | |
|---|---|---|---|---|---|
| | | Дугаар | Үнэ | Дугаар | Үнэ |
| 100164 | АМЬДРАХ УХААН | 6 | 4800 | 4 | 3200 |
| 100624 | АНАГААХ АРГА БИЛИГ | 6 | 9600 | 4 | 6400 |
| 100625 | АНАГААХ АРГА БИЛИГ /2015 ОНЫ ХУУЧИН ДУГААРУУД БАГЦ/ | 1 | 28800 | 1 | 28800 |
| 101560 | ДАЛД АМЬДРАЛ | 6 | 8000 | 4 | 5400 |
| 100001 | МЭРГЭШСЭН НЯГТЛАН БОДОГЧ | 6 | 5400 | 4 | 3600 |
| 109110 | ОНЦГОЙ МЭДЭЭ | 6 | 4500 | 4 | 3000 |
| 100064 | САНХҮҮ БАНКНЫ МЭДЭЭЛЭЛ | 6 | 6000 | 4 | 4000 |
| 163451 | ЭРҮҮЛ МЭНДИЙН ЖОР | 5 | 7500 | 3 | 4500 |

### 6. САР ТУТМЫН СОНИН

| Индекс | ХЭВЛЭЛИЙН НЭР | Улирал | | Нэмэлт | |
|---|---|---|---|---|---|
| | | Дугаар | Үнэ | Дугаар | Үнэ |
| 101081 | БАГШ | 3 | 6000 | 2 | 4000 |
| 100548 | БИЛГИЙН МЭЛМИЙ | 3 | 1500 | 2 | 1000 |
| 115457 | ГЕОЛОГИ УУЛ УУРХАЙН МЭДЭЭ | 3 | 3000 | 2 | 2000 |
| 100520 | ДАЛ /Зөгнөлт сонин, Өнгөрсөн, одоо, ирээдүйн зөн совин, танин мэдэхүйн/ | 1 | 1000 | 1 | 3000 |
| 107990 | Ерөнхий эрдмийн хичээлүүд англи-монгол хэл дээр №1 А.Дүрэм Б. Унших дасгал */Англи хэл сурах үндэсний шилдэг технологи/* | 1 | 5000 | 1 | 5000 |
| 100021 | МОНГОЛЖИНГОО | 3 | 1350 | 2 | 900 |
| 107660 | Математик 1-3 анги /2016-2017 оны хичээлийн жилд захиалаагүй уншигчдад зориулав.№1-№6 | 1 /6 ширхэг 1 багц/ | 12000 | 1 /6 ширхэг 1 багц/ | 12000 |
| 107661 | Математик 4-5 анги /2016-2017 оны хичээлийн жилд захиалаагүй уншигчдад зориулав.№1-№6 | 1 /6 ширхэг 1 багц/ | 12000 | 1 /6 ширхэг 1 багц/ | 12000 |
| 107662 | Математик 6-9 анги /2016-2017 оны хичээлийн жилд захиалаагүй уншигчдад зориулав.№1-№6 | 1 /6 ширхэг 1 багц/ | 10000 | 1 /6 ширхэг 1 багц/ | 10000 |
| 107663 | Математик 10-12 анги /2016-2017 оны хичээлийн жилд захиалаагүй уншигчдад зориулав.№1-№6 | 1 /6 ширхэг 1 багц/ | 12000 | 1 /6 ширхэг 1 багц/ | 12000 |
| 100873 | НЭЭЛТТЭЙ СУРГУУЛЬ | 3 | 1800 | 2 | 1200 |
| 101001 | ОЮУНД ТУССАН ГЭГЭЭ | 3 | 3000 | 2 | 2000 |
| 101227 | УЛАМЖЛАЛТ АНАГААХ УХААН СОНИН | 3 | 3000 | 2 | 2000 |
| 100620 | ХАНЬ | 4 | 5200 | 3 | 3900 |
| 101409 | ХӨДӨӨ АЖ АХУЙН МАРГААШ | 3 | 1500 | 2 | 1000 |
| | ХЭРЭГЛЭГЧИЙН ЭРХ СОНИН | 3 | | | |
| 101539 | СУРАГЧИЙН ЕРТӨНЦ | 3 | 4500 | 2 | 3000 |
| 101016 | СЭТГЭЛ ЗҮЙЧ | 2 | 5400 | 2 | 5400 |
| 101438 | СУРАГЧ | 3 | 9000 | 2 | 6000 |
| 100651 | ЦОХ /хүүхдийн танин мэдэхүйн сонин бүх нүүр өнгөтөөр/ | 3 | 5000 | 2 | 3400 |
| 100813 | ЭМЧ | 3 | 3000 | 2 | 2000 |
| 101655 | Шамбалын гэрэл /2009 оны 12 дугаар/ | 1 | 15000 | 1 | 15000 |
| 1102701 | “Математикийн Цаг” I анги /Хавсралт 2 дугаарт “Өөрийн үнэлгээ 1-р анги” I ба II дэвтэр бэлэглэнэ/. | Үндсэн 6 + хавсралт 2 | 11800 | Захиалагч нарт: “Математикийн Цаг I-V анги” сонины º1-º6 дугааруud болон тухайн ангийн хавсралт 2 дугаарыг багцалж үдсэн байдлаар 1 удаа хүргүүлэх ба багцууд нь зөвхөн хавсралт дугаараар ялгагдана. | |
| 1102702 | “Математикийн Цаг” I анги /Хавсралт 2 дугаарт “Өөрийн үнэлгээ 2-р анги” I ба II дэвтэр нийтэлж бэлэглэнэ/. | Үндсэн 6 + хавсралт 2 | 11800 | | |
| 1102703 | “Математикийн Цаг” I анги /Хавсралт 2 дугаарт “Өөрийн үнэлгээ 3-р анги” I ба II дэвтэр нийтэлж бэлэглэнэ/. | Үндсэн 6 + хавсралт 2 | 11800 | | |
| 1102704 | “Математикийн Цаг” I анги /Хавсралт 2 дугаарт “Өөрийн үнэлгээ 4-р анги” I ба II дэвтэр нийтэлж бэлэглэнэ/. | Үндсэн 6 + хавсралт 2 | 11800 | | |
| 1102705 | “Математикийн Цаг” I анги /Хавсралт 2 дугаарт “Өөрийн үнэлгээ 5-р анги” I ба II дэвтэр нийтэлж бэлэглэнэ/. | Үндсэн 6 + хавсралт 2 | 11800 | | |
| 1102706 | “Математикийн Цаг” I анги /Хавсралт 2 дугаарт “Өөрийн үнэлгээ 6-р анги” I ба II дэвтэр нийтэлж бэлэглэнэ/. | Үндсэн 6 + хавсралт 2 | 11800 | Захиалагч нарт: “Математикийн Цаг VI-IX анги” сонины º1-º6 дугаарууд болон тухайн ангийн хавсралт 2 дугаарыг багцалж үдсэн байдлаар 1 удаа хүргүүлэх ба багцууд нь зөвхөн хавсралт дугаараар ялгагдана. | |
| 1102707 | “Математикийн Цаг” I анги /Хавсралт 2 дугаарт “Өөрийн үнэлгээ 7-р анги” I ба II дэвтэр нийтэлж бэлэглэнэ/. | Үндсэн 6 + хавсралт 2 | 11800 | | |
| 1102708 | “Математикийн Цаг” I анги /Хавсралт 2 дугаарт “Өөрийн үнэлгээ 8-р анги” I ба II дэвтэр нийтэлж бэлэглэнэ/. | Үндсэн 6 + хавсралт 2 | 11800 | | |
| 1102709 | “Математикийн Цаг” I анги /Хавсралт 2 дугаарт “Өөрийн үнэлгээ 9-р анги” I ба II дэвтэр нийтэлж бэлэглэнэ/. | Үндсэн 6 + хавсралт 2 | 11800 | | |
| 1102710 | “Математикийн Цаг” I анги /Хавсралт 2 дугаарт “Өөрийн үнэлгээ 10-р анги” I ба II дэвтэр нийтэлж бэлэглэнэ/. | Үндсэн 6 + хавсралт 2 | 11800 | Захиалагч нарт: “Математикийн Цаг X-XII анги” сонины º1-º6 дугаарууд болон тухайн ангийн хавсралт 2 дугаарыг багцалж үдсэн байдлаар 1 удаа хүргүүлэх ба багцууд нь зөвхөн хавсралт дугаараар ялгагдана. | |
| 1102711 | “Математикийн Цаг” I анги /Хавсралт 2 дугаарт “Өөрийн үнэлгээ 11-р анги” I ба II дэвтэр нийтэлж бэлэглэнэ/. | Үндсэн 6 + хавсралт 2 | 11800 | | |
| 1102712 | “Математикийн Цаг” I анги /Хавсралт 2 дугаарт “Өөрийн үнэлгээ 12-р анги” I ба II дэвтэр нийтэлж бэлэглэнэ/. | Үндсэн 6 + хавсралт 2 | 11800 | | |
| 1102714 | Математикийн ажлын дэвтэр 2-р анги | 1 | 3600 | 2016-2017 оны хичээлийн жилд зориулан шинэчлэн боловсруулж хэвлэсэн. Тухайн ангийн математикийн хичээлээр судалж буй бүлэг сэдэв бүрээр суралцагч бие дааж болон эцэг эхийн хамтаар мэдлэг чадвараа бататгах зорилгоор асуултанд хариулах, нөхөх, гүйцээх, бодож бөглөх зэрэг олон хэлбэрээр ажиллах дэвтэр юм. | |
| 1102715 | Математикийн ажлын дэвтэр 3-р анги | 1 | 3600 | | |
| 1102716 | Математикийн ажлын дэвтэр 4-р анги | 1 | 3600 | | |
| 1102717 | Математикийн ажлын дэвтэр 5-р анги | 1 | 3600 | | |
| 1102718 | Математикийн ажлын дэвтэр 6-р анги | 1 | 3600 | | |
| 1102719 | Математикийн ажлын дэвтэр 7-р анги | 1 | 3600 | | |
| 1102720 | Математикийн ажлын дэвтэр 8-р анги | 1 | 3600 | | |
| 1102721 | Математикийн ажлын дэвтэр 9-р анги | 1 | 3600 | | |
| 1102722 | Математикийн ажлын дэвтэр 10-р анги | 1 | 3600 | | |
| 1102723 | Математикийн ажлын дэвтэр 11-р анги | 1 | 3600 | | |
| 1102724 | Математикийн ажлын дэвтэр 12-р анги | 1 | 3600 | | |

### 7. ОРОН НУТГИЙН ХЭВЛЭЛ

| Индекс | ХЭВЛЭЛИЙН НЭР | Улирал | | Нэмэлт | |
|---|---|---|---|---|---|
| | | Дугаар | Үнэ | Дугаар | Үнэ |
| 101003 | АЛТАН НУТГИЙН МЭДЭЭ /Өмнөговь/ | 3 | 4500 | 2 | 3000 |
| 101239 | АРХАНГАЙН АМЬДРАЛ /Архангай/ | 12 | 6000 | 8 | 4000 |
| 105446 | АЛТАЙН МЭДЭЭ /Говь-Алтай/ | 12 | 6000 | 8 | 4000 |
| 101174 | БАЯНХОНГОР ТАЙМС /Баянхонгор/ | 9 | 6000 | 6 | 4000 |
| 100999 | БУЛГАНЫ МЭДЭЭ /Булган/ | 12 | 6000 | 8 | 4000 |
| 163338 | ДОРНОГОВИЙН ШУУДАН | 6 | 3000 | 4 | 2000 |
| 101157 | ДОРНОД /Дорнод/ | 12 | 6000 | 8 | 4000 |
| 154053 | ДӨЛ /Дорнод/ | 6 | 3000 | 4 | 2000 |
| 101180 | ДАЛАЙ ЭЭЖ | 9 | 7200 | 6 | 4800 |
| 154461 | ДУНДГОВИЙН АМЬДРАЛ /Дундговь/ | 12 | 6000 | 8 | 4000 |
| 100610 | ЗАВХАН /Завхан/ | 12 | 6000 | 8 | 4000 |
| 100802 | МОНГОЛ ГОВЬ /Өмнөговь/ | 12 | 6000 | 8 | 4000 |
| 131363 | МОНГОЛ ЗАМАН | 6 | 4500 | 4 | 3000 |
| 101672 | НАЛАЙХЫН АМЬДРАЛ /Налайх дүүрэг/ | 12 | 6000 | 8 | 4000 |
| 190709 | НАР ТУССАН ЦАГ | 24 | 10000 | 16 | 8000 |
| 100778 | ӨВӨРХАНГАЙН ИЛЧ /Өвөрхангай/ | 12 | 6000 | 8 | 4000 |
| 101004 | ӨВӨРХАНГАЙН ӨНГӨ /Өвөрхангай/ | 12 | 6000 | 8 | 4000 |
| 101666 | ӨНӨӨГИЙН БАЯНХОНГОР | 9 | 4500 | 6 | 3000 |
| 105813 | ӨНӨӨГИЙН ДОРНОГОВЬ /Дорноговь/ | 9 | 6000 | 6 | 4000 |
| 106003 | ӨНӨӨДРИЙН ЯЛАЛТ | 6 | 4200 | 4 | 2800 |
| 101139 | СЭЛЭНГИЙН МЭДЭЭ /Сэлэнгэ/ | 12 | 6000 | 8 | 4000 |
| 201009 | СОНИРХОЛТОЙ ДЭЛХИЙ /сэтгүүл/ | 3 | 6000 | 2 | 4000 |
| 101642 | ТАНЫ ЭЛЧ /Өвөрхангай/ | 12 | 6000 | 8 | 4000 |
| 101624 | УВСЫН ӨНГӨ /Увс/ | 12 | 6000 | 8 | 4000 |
| 101095 | ХОВДЫН МЭДЭЭ /Ховд/ | 12 | 6000 | 8 | 4000 |
| 101607 | ХОВДЫН ТОЛЬ+Бизнес толь+Ирээдүйн толь | 12 | 6000 | 8 | 4000 |
| 193342 | Хотын шуудан /Эрдэнэт/ | 9 | 7000 | 6 | 4600 |
| 101097 | ХЭНТИЙН МЭДЭЭ /Хэнтий/ | 12 | 6000 | 8 | 4000 |
| 101238 | ЦЭЦЭРЛЭГ МАНДАЛ /Архангай/ | 6 | 3000 | 4 | 2000 |
| 101285 | ШИНЭ ЗУУНЫ ХЭНТИЙ | 6 | 3600 | 4 | 2400 |
| 100746 | ЭРХ ЧӨЛӨӨ /Хөвсгөл/ | 12 | 6000 | 8 | 4000 |
| 201045 | ӨВӨРХАНГАЙН ӨНГӨ /Сэтгүүл/ | 3 | 10000 | 2 | 7000 |

# НИЙГЭМ

ЗАСАГ ДАРГА ЯРЬЖ БАЙНА



*Гэрэл зургийг Г.АРГУУЖИН*

# С.Ариунбат:

# “САЙН ХАШАА”, “САЙН ӨВӨЛЖӨӨ” ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛНЭ

Б.ДАВАА

*Сэлэнгэ аймгийн Баянгол сум нь 1931 онд Богдхан уулын аймгийн Баатарвангийн хошууны Хөлий-Баянуул сумын суурин дээр Түнхийн аманд Хараа голын хөндийд байгуулагдсан түүхтэй. 1954 онд Мандах нэгдэл нэртэйгээр үйл ажиллагаа явуулж байгаад 1968 онд Баруунхараа САА болон өргөжин 1992 онд шинэ Үндсэн хуулиар Баянгол сум болон цэцэглэн хөгжиж байна. Тус сум нь хүн амын тоогоор Сэлэнгэ аймгийн 17 сумаас эхнээсээ дөрөвт, газар нутгийн хэмжээгээр 10-т ордог билээ. Эдүгээ сумын Засаг даргаар С.Ариунбат ажиллаж буй бөгөөд гал тахиа жилийн босгон дээр Засаг даргатай ярилцсанаа хүргэе.*

**-Та Баянгол сумын унаган хүү. Өвөө тань ч гэсэн сумын Засаг даргаар ажиллаж байсан тухай сонсч байсан юм байна. Төрөлх сумынхаа хөгжил дэвшлийн төлөө нэн тэргүүнд шийдвэл зохих ямар асуудал байна гэж та харж байна вэ. Энэ асуултаас ярилцлагаа эхлүүлэх үү?**

-Ирэх дөрвөн жилд хэрэгжүүлэх үйл ажиллагааныхаа хөтөлбөртөө эхний ээлжинд “Сайн хашаа”, “Сайн өвөлжөө” хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн. Энэ ажилд иргэдийн туслалцаа, хамтын ажиллагаа шаардлагатай гэдгийг хэлэх хэрэгтэй байх. Мөн Баянгол сумын төвийн дулааны шугам сүлжээний асуудал хүндхэн байгаа. Халаалтын тухайд хэрэглээ өдрөөс өдөрт, жилээс жилд нэмэгдэж байна. Үүнийг дагаад уурын зуухны хүчин чадлыг нэмэгдүүлэх, халаалтын шугамыг шинэчлэх, засварлах ажлыг шат дараатай хийх шаардлага гарч байгаа. Мөн автозамын засвар шинэчлэлтийн ажлуудыг төлөвлөж байна. Баянгол сумын нутаг дэвсгэрээр дайрч өнгөрөх олон улсын зэрэглэлтэй автозамыг 2000 онд БНХАУ-ын хөрөнгө оруулалтаар барьж ашиглалтад оруулсан байдаг. Гэвч, замын ашиглалтын хугацаа дуусч, эвдэрч гэмтсэний улмаас осол аваар их гарах болсон.

**-Сэлэнгэ аймаг өвөлжилт хүндэрсэн аймгуудын тоонд багтаж байгаа. Баянгол сумын өвөлжилтийн байдал хэр байна вэ?**

-Манай сумын хүн амын тоо 5516. Гурван баг, 1616 өрхтэй. Төр төсвийн есөн байгууллагатай. Аймгийн хэмжээнд хүн амынхаа тоогоор дөрөвдүгээрт, газар нутгийн хэмжээгээр аравт ордог том сумын нэг. Мал тооллогын эцсийн дүнгээр 148862 толгой мал тоологдсон. Үүнээс 8736, үхэр 18389, хонь 77715, ямаа 44012 тоологдсон. Өвөлжилтийн тухайд цасихтэй, зудархуу нөхцөл байдалтай байгаа. Цаг үеийн нөхцөл байдалтай холбогдуулан бэлтгэлээ базааж, өвс тэжээл хүрэлцэхүйц хэмжээнд нөөцөлсөн. Газар тариалан эрхлэгч ААН, иргэдийн эргэлтийн талбайгаас хамаарч сумын аюулгүй фондод 13.4 тонн тэжээлийн будаа, “Бороо Гоулд” ХХК-ийн уурхайн эдэлбэр газраас 2862 боодол өвс бэлтгэлээ. Түүнчлэн, сумын фондод өвс, тэжээл нэмж нөөцлөх зорилгоор “Бороо” сангаас 20 сая төгрөгийн хөрөнгө оруулалтыг зээлээр авсан. Өвөлжилт хүндэрсэн үед малчиддаа хүргэхээр төлөвлөж байна.

**-Ирэх жилүүдэд суманд хийхээр төлөвлөсөн бүтээн байгуулалтын ажлууд байгаа байх. Тэднээс хамгийн түрүүнд шийдвэрлэвэл зохих онцлох ажлуудаасаа дурьдахгүй юу?**

-Сүүлийн жилүүдэд манай багт тамирчид спортын чиглэлээр улсад өндөр амжилт үзүүлэх болсон. Гандбол, сагсан бөмбөг, жүдо бөхийн төрлөөр бахархам амжилт гаргаж байгаа. Сүүлийн хоёр жил сагсан бөмбөгийн тамирчид маань спрайт лигт дөрөвдүгээр байр эзэлсэн бол гандболын эрэгтэй, эмэгтэй төрөл тус бүрээр өсвөрийн улсын аваргууд манай сумаас төрсөн. Гар бөмбөгийн спорт ч хөгжиж байна. Манай сумын унаган хүү Э.Үнэнхүү гэхэд л 2016 оны ДАШТ-д жүдо бөхийн төрлөөр амжилттай оролцлоо. Энэ бүх амжилт сумын спортын хөгжил ямар төвшинд байгааг илтгэж байгаа хэрэг. Тиймээс цаашид тамирчдаа дэмжиж, илүү том амжилт гаргах боломж нөхцлөөр нь хангахын тулд спорт цогцолборынхоо үйл ажиллагааг тогтвортой явуулах ёстой. Тиймээс сумын спорт цогцолборынхоо дээврийн засварыг зайлшгүй хийх шаардлагатай байгаа. Бас Түнхийн хийдийн туурьт хийдийг босгох ажлыг зохион байгуулаад явж байна. Түүнчлэн, эх, хүүхдийн эрүүл мэндийг хамгаалах төвийг байгуулахаар мөн төлөвлөсөн.

**-Баянголд хоёр жилийн өмнө ургамлын тосны бүрэн автомат үйлдвэр нээлтээ хийж байсан. Тухайн үед “Оргих” гэж ургамлын тос үйлдвэрлэж байсан шүү дээ. Гэвч одоогоор дэлгүүрт зарагдаж харагдахгүй юм. Үйл ажиллагаа нь хэвийн үргэлжилж байгаа юу?**

-Үйл ажиллагаа нь үргэлжилж байгаа. Гэхдээ байгуулагдаад удаагүй учир жигдэрч амжаагүй л байна. Ургамлын тосны үйлдвэрт манай сумаас 50 гаруй хүн ажилладаг. Тухайн байгууллагын менежмент, борлуулалт, савлагаанд бага зэргийн хүндрэл гарсан. Компани асуудлаа шийдчихвэл сумын 40-50 иргэн байнгын ажлын байраар хангагдах бололцоотой.

**-Танай суманд элсэн чихэрийн үйлдвэр ч байдаг байх аа?**

-Элсэн чихэрийн үйлдвэр ажиллахгүй байгаа. Уг нь үйлдвэрийн барилга, тоног төхөөрөмж нь бий. Гол асуудал нь элсэн чихэрийн манжин нь шаардлагатай технологийн хэмжээнд хүртэл ургаж чадахгүй байгаа юм. Энэ дашрамд дурьдахад, цаашдаа төмс, хүнсний ногоо тариалалт дээрээ тулгуурлан пүнтүүзний үйлдвэрийг барихаар яриа хэлэлцээр хийгдсэн. Энэ чиглэлийн үйлдвэрлэл эрхлэх сонирхолтой хүмүүс ирж уулзаж, санал тавьсан юм. Үйлдвэр баригдсанаар иргэд маань ажлын байраар хангагдаж, иргэдийн орлого нэмэгдэх учраас бидний хувьд татгалзах зүйл үгүй.

**-Танайх иргэддээ нэг хувийн хүүтэй зээл олгодог гэсэн. Энэ зээлийн үр шимээр хөл дээрээ босч, бизнесээ эхлүүлсэн олон хүн байдаг юм билээ?**

-Манай суманд “Бороо гоулд” компани 2000 оноос үйл ажиллагаа явуулж эхэлсэн. Нийгмийн хариуцлагын хүрээнд орон нутагт маань тодорхой хэмжээний хөрөнгө оруулалт хийдэг юм. Түүнийг нь үргүй зүйлд зарцуулаагүй. Тодорхой хувийг нь сумандаа, иргэддээ шаардлагатай үед нь тусламж, дэмжлэг үзүүлэх зорилгоор зарцуулдаг. “Бороо сан”-г зээлийн шугамаар баталж, үйл ажиллагааг нь явуулж байна. Өнөөдрийн байдлаар энэхүү сан маань 300 сая төгрөгтэй, үлдэгдэл мөнгө нь 120 сая төгрөг байна. Иргэдийн гар дээр 180 сая төгрөг зээл хэлбэрээр эргэлдэж байгаа гэсэн үг. Зээлийн сангийн хөрөнгийг зорилтот бүлэг буюу ногоочид, төрийн байгууллагын ажилтан, алба хаагчид мэргэжил боловсролоо дээшлүүлэхэд ашигладаг. Мөн ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ч олгодог зээл бий.

PHOTO NEWS

# “Газар хөдлөлтийн аюулаас урьдчилан сэргийлэх, таниулах өдөр” тохиож байна

Б.АЛТАНБАГАНА

“Газар хөдлөлтийн аюулаас урьдчилан сэргийлэх, таниулах өдөр” тохиож байгаа билээ. Уг өдрийг тохиолдуулан үндэсний хэмжээнд иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудыг оролцуулан газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах, бэлэн байдлыг хангах, өөрийгөө хамгаалах дадлыг хэвшүүлэх, хүүхэд залуучуудад зориулан танин мэдэхүйн нэвтрүүлэг бэлтгэх зэрэг олон арга хэмжээг хэрэгжүүлж байгаа ажээ. Мөн Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 399, 340 дүгээр тогтоолоор батлагдсан “Гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийн дохио дамжуулах журам”, “Гамшгийн үеийн дайчилгаа, нүүлгэн шилжүүлэх журам”-ын дагуу жил бүрийн гуравдугаар сарын дөрөв дэх пүрэв гарагийн 16:00 цагт гамшгийн аюулыг зарлан мэдээлэх дохиогоор дадлага сургуулийг зохион байгуулдаг. Энэ жил мөн адил хоёр удаа дуут дохио ажиллуулж, дадлага хийх юм байна. Эхний дуут дохиогоор төрийн захиргааны байгууллага, аж ахуйн нэгж, гамшгаас хамгаалах улсын албад, ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгүүд газар хөдлөлтийн үеийн аюулгүй ажиллагааны “Нуугд-Суу-Хүлээ” зарчмыг баримтлан өрөө тасалгаандаа аюул багатай байрлалд өөрийгөө хамгаалан ширээн доогуур орох, даацын хана, булан тохойд зогсох юм байна. Харин хоёр дахь дохио дуугарсны дараа барилга, объектыг орхин гарахдаа гарын доорх зүйл ашиглан толгойгоо хамгаалах хэрэгтэй аж. Мөн гүйхгүй, эргэж буцахгүй, хашхирахгүй, түлхэлцэхгүй гэсэн зарчмаар аврах гарцаар гарч, аюулгүй зай талбайд цугларч дадлага сургуульд оролцох юм байна. Мөн энэхүү өдрийг тохиолдуулан гамшигт тэсвэртэй хөтөлбөрийг хэрэгжүүлэн ажиллаж байгаа нийслэлийн Онцгой байдлын газар, Хүүхэд гэр бүл хөгжлийн газар, Боловсролын газар, Эрүүл мэндийн газруудад “Дэлхийн зөн Монгол” олон улсын байгууллагаас газар хөдлөлтийн аюулаас урьдчилан сэргийлэх багаж, техник тоног төхөөрөмжийг хүлээлгэн өгсөн юм.





*Гэрэл зургийг Г.АРГУУЖИН*











## Хүчингүйд тооцов

9011533123 улсын бүртгэлийн дугаартай 5952158 регистрийн дугаартай “ИХ ИТГЭЛТ” ХХК нь татан буугдсан тул хүчингүйд тооцов.

Ч.Нямаа, А.Мөнхтуул нарын хамтын эзэмшлийн БГД 8р хороо 10 р байрны 79 тоот байрны Ү-2205003904 Улсын бүртгэлийн дугаартай 000116765 гэрчилгээний дугаартай үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээ гээсэн тул хүчингүйд тооцов

# NO STRESS

ДЭЛХИЙН ШИЛДЭГ ГЭРЭЛ ЗУРАГ



# Стэнд-н Рок

Б.СУМЪЯА

Энэ зураг дэлхийн хэвлэлийн шилдэг гэрэл зураг шалгаруулах “World press photo-2017” наадмын “орчин үеийн асуудал” төрөлд тэргүүн байр эзэлжээ. Канадын гэрэл зурагчин Амбер Бракен газрын тос дамжуулах хоолойтой холбоотой сөргөлдөөн хурцадмал байдалд орсон АНУ-ын Хойд Дакотад 2016 оны арванхоёрдугаар сарын 5-нд энэ зургийг авсан байна. Газрын тос дамжуулах хоолой тавих эсэх талаарх сөргөлдөөн үүссэн бүсэд АНУ болон уг үйл ажиллагааг эсэргүүцэгч Мохавк Вариорс нийгэмлэгийн далбаа зэрэгцэн намирч буйг зурагчин дурандаа ийн буулгажээ.

Тус хоолой Хойд Дакотагаас АНУ-ын Иллинойс мужийн усан онгоцны зогсоол хүртэл газар доогуур 1886 км үргэлжлэх бөгөөд 2016 онд хоолойн ихэнх хэсгийг барьж гүйцэтгэсэн хэдий ч орон нутгийн иргэдийн эсэргүүцлийн улмаас түр зогсоосон байдаг. “Стэнд-н Рок” овгийн хүмүүс газар тос дамжуулах хоолой эвдэрч хэмхэрсэн тохиолдолд ундны усыг бохирдуулж иргэдийн эрүүл мэндэд сөргөөр нөлөөлнө гэж үздэг аж. Учир нь тус бүсийн ундны усны гол эх үүсвэр болох Миссури голын доогуур хоолой тавигдах гэнэ. Ямартай ч, энэ зураг жил бүр зохион байгуулагддаг Дэлхийн хэвлэлийн шилдэг гэрэл зураг шалгаруулах “World press photo-2017” наадмын шилдгээр тодорлоо. Энэ удаагийн тэмцээнд дэлхийн 125 орны 5034 зурагчин 80400 бүтээлээ илгээснээс дээрх зураг шилдгийн шилдгээр шалгарчээ.

Улаанбаатарт:

Маргааш

Өдөр 1
Шөнө -10

Нөгөөдөр

Өдөр 3
Шөнө -10

## Өдрийн зурхай

**ХАВРЫН ТЭРГҮҮН ХАР БАР САР НЭГ ЦАГААН МЭНГЭТЭЙ ШАРАГЧИН ТАХИА ӨДӨР**

**Наран ургах шингэх:** 06.49-19.09
**Үс засуулбал:** Нүд бүрэлзэн улцайна



*Тухайн өдөр бар, туулай, бич, тахиа жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба үхэр, луу, хонь, нохой жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Хувцас хийх, гэр орон барих, сан нуун дарахад сайн. Зүүн нүд татвал эцэг, эх садны хэрэг бүтэх баруун нүд татвал эд олдох, зүүн чих хангинавал аймшиг болох, баруун чих хангинавал хэрүүл тэмцэл болох, хэрээ дуугарвал зочид ирэх, тагнай загатнавал сэтгэл зовох, бүх бие татвал хэрэг олон болох, хөл татвал үзэсгэлэн болно. Өдрийн сайн цаг нь хулгана, бар, туулай, морь, хонь, тахиа болой.*

СОНИРХУУЛАХАД

## “I phone-7” УЛААН ӨНГӨТЭЙГӨӨР худалдаанд гарна

Ухаалаг гар утасны салбартаа тэргүүлэгч “Apple” компани тун удахгүй улаан өнгийн “I phone-7” гар утсыг худалдаанд гаргахаар болсноо өчигдөр мэдэгджээ. Шинэ өнгөтэйгөөр худалдаанд гарах утас улаан өнгийн хөнгөн цагаан гадаргуутай байх бөгөөд тус утасны борлуулалтын тодорхой хувь нь ДОХ-той тэмцэх олон улсын санд хандивлагдах аж. Шинэ бүтээгдэхүүн танилцуулах үйл ажиллагааны үеэр “Apple” компанийн Ерөнхий захирал Тим Кук “Улаан өнгийн I phone-7-ын шинэ хувилбарыг “RED” компанитай хамтран гаргаж байна. Энэ нь “Product RED нэртэй хамгийн том бүтээгдэхүүн байх бөгөөд түүнийг үйлчлүүлэгчдийн гарт хүргэх өдрийг тэсэн ядан хүлээж байна” гэжээ. Улаан өнгөтэй “iPhone 7” болон “iPhone 7 Plus" загваруудын өнгө нь одоо байгаа бүх өнгөнүүдээс хамгийн содон нь болж байгаа юм. Утас энэ сарын 24-нөөс худалдаанд гарна.



Бидэнд тохиолдсон хүндхэн хөгтэй явдлууд

**Г.Золжаргал**

Хамаатны ахын эхнэр нь төрөх гээд гэнэт өвдөөд ахад “Түргэн дууд” гэж гэнэ. Ах түргэн рүү залгаснаа “Өө байна. Түргэн үү. Жирэмсний зар өгөх гэсэн юм аа” гэж л дээ. Тэгсэн эгч инээгээд “Болилоо. Тасал. Чи чинь юу яриад байгаа юм бэ” гэсэн чинь ах дахиад түргэн рүү залгаснаа “Жирэмсний зар өгсөн залуу байна аа. Өөрсдөө очий доо...болилоо” гэсэн гэнээ. Хаха

FOOTBALL NEWS

## “Барселона”, “Реал”-ын тасалбар Майамид 20 минутын дотор борлогдож дуусчээ



Испанийн алдарт хоёр баг болох “Барселона” болон “Реал Мадрид”-ын нөхөрсөг тоглолтын 60 мянган тасалбар Майамид 20 минутын дотор борлогдож дууссан талаар Infobae.com мэдээлжээ. Тиймээс ирэх долдугаар сарын 29-нд болох тоглолтын үеэр Хард Рок цэнгэлдэх хүрээлэнд 65 мянган үзэгч багтаах төлөвлөгөө гаргаад байгаа аж. Тоглолтын тасалбарын хамгийн хямд нь 35 ам.долларын үнэтэй аж. Гэхдээ ихэнх тасалбарыг 1000 ам.доллараар зарсан юм байна. Мөн зарим тасалбарын үнэ бүр 25 мянган ам.доллар хүрсэн ажээ. Хоёр баг анх удаа удаа АНУ-д тоглох гэж байгаа нь энэ юм байна. Харин өмнө нь 1982 онд Венесуэлд тоглож, “Реал Мадрид” өрсөлдөгчөө 1:0-ээр буулгаж авч байжээ. Ер нь бол хоёр баг Майамид Олон улсын Аваргуудын цомын тэмцээний хүрээнд нөхөрсөг тоглолт хийх гэж байгаа нь энэ аж. Түүнээс гадна “Барса” долдугаар сарын 22-нд Нью-Йорк хотноо “Ювентус”-тэй тоглох бол “Манчестер Юнайтед”-тай долдугаар сарын 25-нд Вашингтон хотод тоглох юм байна.




